САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

# БАНКНААС БУСАД САНХҮҮГИЙН САЛБАРЫН ТОЙМ 2017 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРАЛ

УЛААНБААТАР ХОТ

2017 он

АГУУЛГА

**I. 2017 ОНЫ I УЛИРЛЫН ХУРААНГУЙ ТОЙМ** ..... 6
1.1 ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ ..... 6
1.1.1 Үнэт цаасны зах зээл ..... 6
1.1.2 ХАА-н гаралтай бараа, түүхий эдийн зах зээл ..... 6
1.2 ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ ..... 6
1.3 БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА ..... 7
1.4 ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО ..... 7
**II. БАНКНААС БУСАД САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨГЖИЛ** ..... 8
2.1 ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ ..... 9
2.1.1 Үнэт цаасны зах зээл ..... 9
2.1.2 ХАА-н гаралтай бараа, түүхий эдийн зах зээл ..... 10
2.2 ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ ..... 12
2.3 БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА ..... 17
2.4 ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО ..... 19
**III. ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ** ..... 21
3.1 ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ ..... 22
3.1.1 Үнэт цаасны зах зээл ..... 22
3.1.2 ХАА-н гаралтай бараа, түүхий эдийн зах зээл ..... 24
3.2 ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ ..... 25
3.3 БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА ..... 27
3.4 ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО ..... 28
**IV. БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ** ..... 31
4.1 ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ ..... 32
4.1.1 Үнэт цаасны зах зээл ..... 32
4.1.2 ХАА-н гаралтай бараа, түүхий эдийн зах зээл ..... 33
4.2 ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ ..... 34
4.3 БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА ..... 36
4.4 ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО ..... 37
**V. АШИГТ АЖИЛЛАГАА** ..... 39
5.1 ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ ..... 40
5.1.1 Үнэт цаасны зах зээл ..... 40
5.2 ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ ..... 41
5.3 БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА ..... 44
5.4 ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО ..... 44
**VI. ТОГТВОРТОЙ БАЙДАЛ** ..... 46
6.1 БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА ..... 47
6.2 ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО ..... 48
**ХАВСРАЛТ** ..... 50

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1: Даатгалын салбарын мэргэжлийн оролцогчид ....13
Хүснэгт 2. ББСБ-уудын зах зээлд эзлэх хувь ....18
Хүснэгт 3: Хувьцаат компанийн өмчийн хэлбэр, тоо ....22
Хүснэгт 4: Хувьцаат компанийн хувьцааны бүтэц ....23
Хүснэгт 5: Зохицуулалттай этгээдийн тоо ....24
Хүснэгт 6: Үнэт цаасны арилжааны үзүүлэлт ....32
Хүснэгт 7: Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас /тэрбум төгрөгөөр/ ....33
Хүснэгт 8: ХАА-н биржийн арилжааны хэмжээ, дүн ....34
Хүснэгт 9: Нийт хөрөнгө /тэрбум төгрөгөөр/ ....40
Хүснэгт 10: Нийт орлого /сая төгрөгөөр/ ....40
Хүснэгт 11: ХЗХ-дын ашгийн хэмжээ /бүлгээр/ ....45
Хүснэгт 12: Алтманы индекс ....48
Хүснэгт 13: ХЗХ-дын хадгаламжийн үйл ажиллагаа /тэрбум төгрөгөөр/ ....49

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1: Зах зээлийн үнэлгээ ба бодит ДНБ-ий өсөлт ....9
Зураг 2: ЗЗҮ ба хөрвөх чадвар ....10
Зураг 3: ТОП-20 индекс ....10
Зураг 4: ХАА-н биржийн арилжаа /тэрбум төгрөгөөр/ ....11
Зураг 5: MAPIX индекс ....11
Зураг 6: Даатгалын зах зээлийн бүтэц ....12
Зураг 7: Ердийн даатгалын компаниудын зах зээлд эзлэх хувь ....13
Зураг 8: Даатгалын гүнзгийрэлтийн түвшин ....14
Зураг 9: Даатгалын салбарын нийт хөрөнгө ....15
Зураг 10: Даатгалын компанийн хөрөнгийн өсөлтийн тархалт ....15
Зураг 11: Хураамжийн орлого ....15
Зураг 12: Нөхөн төлбөр, давхар даатгалын хураамж ....16
Зураг 13: Нөөц сангийн хэмжээ, өсөлт ....16
Зураг 14: Нийт хөрөнгө ба ДНБ-ий харьцаа ....17
Зураг 15: ББСБ ба харилцагчдын тоо ....18
Зураг 16: ХЗХ-дын тоо /бүс нутгаар/ ....19
Зураг 17: ХЗХ-д ба гишүүдийн тоо /мянгаар/ ....20
Зураг 18: Нийт хөрөнгө ба ДНБ-ий өөрчлөлт ....20
Зураг 19: Хөрөнгө оруулагчдын арилжаанд эзлэх хувь ....22
Зураг 20: Хөдөө орон нутгууд дахь брокеруудын байршил ....24
Зураг 21: ХАА-н гаралтай бараа, түүхий эдийн арилжаа /бүтээгдэхүүнээр/ ....24
Зураг 22: Даатгалын нягтрал /төгрөгөөр/ ....25
Зураг 23: Даатгалын компани болон зуучлагчдын салбаруудын байршил /аймгуудаар/ ....26
Зураг 24: Даатгалын компани болон зуучлагчдын салбаруудын байршил /дүүргээр/ ....26
Зураг 25. ББСБ-уудын тархалт ....27
Зураг 26. ББСБ-ын тоо /аймаг, дүүргээр/ ....27
Зураг 27. Зээлдэгчдийн тоо /дүүргээр/ ....28
Зураг 28. Зээлдэгчдийн тоо /аймгаар/ ....28
Зураг 29: ХЗХ-дын хүртээмжтэй байдал /дүүргүүдээр/ ....29
Зураг 30: ХЗХ-дын хүртээмжтэй байдал /бүсээр/ ....29
Зураг 31: ХЗХ-дын тоо өсөлтийн хувь ....30

Зураг 32: Хувьцааны арилжаа /тэрбум төгрөгөөр/ ....32
Зураг 33: Нийт зуучлагчдын даатгалын хураамжийн орлого /бүтцээр/ ....35
Зураг 34: Даатгалын төлөөлөгчөөр дамжиж орсон хураамжийн орлого ....35
Зураг 35: Даатгалын хохирол үнэлгээний орлого ....36
Зураг 36. ББСБ-ын бүтээгдэхүүн, үйлчилгээний орлого ....36
Зураг 37: ХЗХ-дын бүтээгдэхүүн үйлчилгээнээс олсон орлого ....37
Зураг 38: ХЗХ-дын бүтээгдэхүүн үйлчилгээнээс гарсан зардал ....38
Зураг 39: ҮЦК-иудын тоо /брокер, дилер/ ....41
Зураг 40: Цэвэр ашиг ....42
Зураг 41: Цэвэр ахиуц, хосолсон харьцаа ....42
Зураг 42: Нийт хөрөнгө, өөрийн хөрөнгийн өгөөж ....43
Зураг 43: Хөрөнгийн өгөөж ....44
Зураг 44: ББСБ тус бүрийн хөрөнгийн өгөөж ....44
Зураг 45: ХЗХ-дын ашигт ажиллагаа /тэрбум төгрөгөөр/ ....45
Зураг 46: Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн хувь ....47
Зураг 47: ББСБ бүрийн хугацаа хэтэрсэн ба чанаргүй зээлийн хувь ....47
Зураг 48: Нийт зээл болон чанаргүй зээл /тэрбум төгрөгөөр/ ....48
Зураг 49: ХЗХ-дын зээлийн чанар /тэрбум төгрөгөөр/ ....49

## ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ

Хавсралт 1: Хөрөнгийн зах зээлийн статистик үзүүлэлт /тэрбум төгрөгөөр/ ....50
Хавсралт 2: Даатгалын зах зээлийн статистик үзүүлэлт /тэрбум төгрөгөөр/ ....51
Хавсралт 3: ББСБ-уудын статистик үзүүлэлт (тэрбум төгрөгөөр) ....52
Хавсралт 4: ХЗХ-дын статистик үзүүлэлт (тэрбум төгрөгөөр) ....53

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

| | |
|---|---|
| АНУ | Америкийн Нэгдсэн Улс |
| АТТ | Арилжааны төлбөр тооцоо |
| ББСБ | Банк бус санхүүгийн байгууллага |
| БНХАУ | Бүгд Найрамдах Хятад Ард Улс |
| БНСУ | Бүгд Найрамдах Солонгос Улс |
| ДНБ | Дотоодын нийт бүтээгдэхүүн |
| ЗГ | Засгийн газар |
| ЗГҮЦ | Засгийн газрын үнэт цаас |
| ЗЗҮ | Зах зээлийн үнэлгээ |
| МББСБХ | Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбоо |
| МИК | Монголын ипотекийн корпораци |
| МҮЦАЭХ | Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо |
| МХБ | Монголын хөрөнгийн биржс |
| МХЗХҮХ | Монголын хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбоо |
| ОССК | Орон сууцны санхүүжилтийн корпораци |
| СЗХ | Санхүүгийн зохицуулах хороо |
| ТӨХХК | Төрийн өмчит хязгаарлагдмал хувьцаат компани |
| ҮЦК | Үнэт цаасны компани |
| ҮЦТТТХТ | Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв |
| ҮЦТХТ | Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв |
| ХАА | Хөдөө аж ахуй |
| ХЗХ | Хадгаламж, зээлийн хоршоо |
| ХНХ | Хувь нийлүүлсэн хөрөнгө |
| ХК | Хувьцаат компани |
| ХОМК | Хөрөнгө оруулалтын менежментийн компани |
| ХОС | Хөрөнгө оруулалтын сан |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |
| ЭЗБХ | Эдийн засгийн байнгын хороо |
| OECD | Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага |
| MAPIX | Монголын хөдөө аж ахуйн барааны үнийн индекс |

# I. 2017 ОНЫ I УЛИРЛЫН ХУРААНГУЙ ТОЙМ

## 1.1 ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

### 1.1.1 Үнэт цаасны зах зээл

Хөрөнгийн зах зээл дээр 2017 оны 1 дүгээр улиралд хувьцааны зах зээлийн үнэлгээ 1,429.2 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 10.2 хувиар буюу 131.9 тэрбум төгрөгөөр өссөн нь өмнөх оны эцсийн дүнтэй харьцуулахад 3 хувиар буюу 44.9 тэрбум төгрөгөөр буурсан дүн юм.

Тайлант хугацаанд ТОП-20 индекс өмнөх оны мөн үеэс 12.3 хувиар өсөж 12,451.01, MSE ALL индекс 2.2 хувиар өсөж 820.49 нэгжид хүрсэн бол 2016 оны жилийн эцэстэй харьцуулахад ТОП-20 индекс 0.04 хувиар, MSE ALL индекс 4.73 хувиар тус тус буурсан байна. 2017 оны 1 дүгээр улиралд “Монголын хөрөнгийн биржь” ХК-иар дамжуулан 138 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн. Үүний 86.4 хувийг ЗГҮЦ-ны анхдагч зах зээлийн арилжаа, 9.9 хувийг ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжаа, үлдсэн 3.6 хувийг хувьцааны арилжаа бүрдүүлсэн байна.

### 1.1.2 ХАА-н гаралтай бараа, түүхий эдийн зах зээл

2017 оны 1 дүгээр улирлын байдлаар хөдөө аж ахуйн биржийн өдрийн арилжааны дундаж дүн 905 сая төгрөг байсан бөгөөд 3 дугаар сарын 28-нд хамгийн их буюу 4.7 тэрбум төгрөг, 3 дугаар сарын 3-нд хамгийн бага буюу 67.2 сая төгрөгийн арилжаа хийсэн байна. Арилжигдсан барааны хэмжээний 39 хувийг ямааны завод ноос, 19 хувийг хонины завод ноос, 34 хувийг хонины ноос, 6 хувийг ноолуур, 1 хувийг тэмээний ноосны арилжаа бүрдүүлсэн байна.

## 1.2 ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ

Тайлант хугацаанд даатгалын салбарын нийт хөрөнгийн хэмжээ 2016 оны 1 дүгээр улиралтай харьцуулахад 19.0 хувиар өсөж, 224.8 тэрбум төгрөгт хүрсэн нь 2016 оны ДНБ-ий 0.94 хувийг эзэлж байна. Ердийн даатгалын компаниуд, урт хугацааны даатгалын компани болон давхар даатгалын компанийн нийт хөрөнгө 19.3 хувь, 0.4 хувь, 23.7 хувиар тус тус өслөө. Нөөц сангийн хэмжээг нэмэгдүүлсэнтэй холбоотойгоор нийт актив дахь хөрөнгө оруулалтын хэмжээ 2017 оны 1 дүгээр улиралд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 51.7 тэрбум төгрөгөөр өссөн нь салбарын нийт хөрөнгийн өсөлтөөс давсан үзүүлэлт байв.

Даатгалын компаниудын нийт хураамжийн орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад 37.8 хувиар өсөж 37.5 тэрбум төгрөгт хүрсэн ба үүнд ердийн даатгалын компаниудын хураамжийн орлогын өсөлт 36 хувь, урт хугацааны даатгалын компанийн хураамжийн орлого 30.8 хувь тус тус өсөв. Салбарын хэмжээнд нийт хураамжийн орлогоос давхар даатгалын хураамжийн зардалд 53.4 хувийг, нийт нөхөн төлбөрийн зардалд 23.5 хувийг, үйл ажиллагааны зардалд 22.9 хувийг зарцуулсан.

Ердийн даатгалын компаниудын татварын дараах цэвэр ашиг сөрөг утгатай буюу алдагдалтай гарсан нь салбарын цэвэр ашгийн хэмжээг буурахад хүргэлээ. Үүнд үйл ажиллагааны зардлын өсөлт болон даатгалын гэрээний зардлын өсөлт нөлөөлөв.

## 1.3 БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

Тайлант улиралд ББСБ-ын тоо 13-аар нэмэгдэн, 2 ББСБ-ын үйл ажиллагааг хүчингүй болгосноор 529-д хүрсэн бол нийт хөрөнгийн хэмжээ 11.1 тэрбум төгрөг буюу 1.4 хувиар өссөн. Нийт хөрөнгийн бүтэц дэх хувь нийлүүлсэн хөрөнгө 69.2 тэрбум төгрөг буюу 16 хувиар өссөн бол нийт өр төлбөр 45.9 тэрбум төгрөг буюу 22 хувиар буурсан байна. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг СЗХ-оос нэмэгдүүлсэнтэй холбоотой ийнхүү их хэмжээгээр нэмэгдсэн бол ББСБ-ууд тайлант улиралд богино хугацаат өр төлбөрөө барагдуулсантай холбоотой нийт өр төлбөрийн хэмжээ багасжээ.

Тайлант үед салбарын цэвэр ашиг өмнөх оны мөн үеэс 0.2 тэрбум төгрөг буюу 1.5 хувиар өсөж 12.9 тэрбум төгрөгт хүрсэн байна. Ашиг нэмэгдэхэд зээлийн орлого болон Засгийн газрын үнэт цаасны хүүгийн орлогын өсөлт, хүүгийн зардлын бууралт нөлөөлөв.

ББСБ-уудын нийт зээлийн үлдэгдлийн 97 хувь нь Улаанбаатар хотод, харин үлдсэн 3 хувь нь 20 аймгийн зээлдэгчдэд ногдож байна.

Тайлант улиралд ББСБ-уудын бүтээгдэхүүн, үйлчилгээний орлогоос зээлийн хүүгийн орлого хамгийн их хувийг эзэлсэн хэвээр байгаа бол картын үйлчилгээний орлого шинээр нэмэгдэв.

ББСБ-уудын хувь нийлүүлсэн хөрөнгө өссөнөөр бие даасан, эрсдэл даах чадвар сайжирч байгаа бол чанаргүй зээлийн хэмжээ нэмэгдсээр байна.

## 1.4 ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО

Тайлант улиралд СЗХ-оос хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр 2 ХЗХ-д олгож, 16 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийн хугацааг сунган, 3 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлснээр нийт ХЗХ-дын тоо өмнөх оны мөн үеэс 4.1 хувиар өсөж 282 болов. Нийт гишүүдийн тоо 14.6 хувиар буюу 6,101 гишүүдээр нэмэгдэж 47,918 болсон байна.

Нийт хөрөнгийн хэмжээ 19.9 хувиар буюу 20.2 тэрбумаар өсөж 121.7 тэрбум төгрөгт хүрсэн нь нэрлэсэн ДНБ-ийн 2.1 хувийг эзэллээ. Нийт цэвэр зээл тайлант хугацаанд 19.5 хувиар өссөн нь нийт хөрөнгийн өсөлтийн 75.5 хувийг бүрдүүлэв. Нийт хөрөнгийг бүтцээр авч үзвэл нийт цэвэр зээл 76.8 хувь, мөнгөн хөрөнгө 16.5 хувь байна.

ХЗХ-дын нийт зээл тайлант улиралд 96.7 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 20.4 хувиар буюу 16.4 тэрбум төгрөгөөр өссөн байна. Чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 29.7 хувиар өсөж нийт зээлд эзлэх хувь 0.3 хувиар нэмэгдэж 4.6 хувьд хүрсэн байна. Чанаргүй зээл болон хугацаа хэтэрсэн зээлийн нийт зээлд эзлэх хувь өссөөр байгаа бол хэвийн зээл 2013 оноос хойш буурсаар тайлант улиралд 90.2 хувьд хүрсэн.

Тайлант үеийн цэвэр ашиг өмнөх оны мөн үеэс 138.4 сая төгрөгөөр буюу 22.2 хувиар буурч 484 сая төгрөг болсон байна. Хүүгийн орлого өмнөх оны мөн үеэс 9.6 хувиар өсөж 6.5 тэрбум төгрөгт хүрч нийт зарлага 13.4 хувиар өсөж 3.5 тэрбум төгрөгт хүрсэн байна.

# II. БАНКНААС БУСАД САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨГЖИЛ

## 2.1 ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

### 2.1.1 Үнэт цаасны зах зээл

Хөрөнгийн зах зээлийн бүтэц: 2017 оны 1 дүгээр улирлын байдлаар үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогч байгууллагуудын хувьд үнэт цаасны арилжаа эрхлэх 2, үнэт цаасны төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэх 1, төвлөрсөн хадгаламжийн 1, кастодиан банкны үйлчилгээ үзүүлэх 3 банк, мөнгөн төлбөрийн үйл ажиллагаа эрхлэх 5 банк, хөрөнгө оруулалтын менежментийн 14 компани, хөрөнгө оруулалтын 4 сан, брокер, дилерийн 62 компани, андеррайтерийн /давхардсан тоогоор/ 25, хөрөнгө оруулалтын зөвлөхийн /давхардсан тоогоор/ 16 компани, үнэт цаасны итгэмжлэн удирдах 1 компани тус тус үйл ажиллагаа явуулж байна.

Зах зээлийн үнэлгээ: Үнэт цаасны зах зээлийн багтаамж, түүний эдийн засагт үзүүлэх нөлөөг дунд болон урт хугацаанд дэмжигч гол үзүүлэлт нь үнэт цаасны зах зээлийн үнэлгээ (ЗЗҮ) бөгөөд үүний өсөлт, бууралт нь үнэт цаасны зах зээлийн хөгжлийн түвшинг илэрхийлэгч үндсэн индикатор болдог.

2017 оны 1 дүгээр улирлын байдлаар үнэт цаасны зах зээлийн үнэлгээ 1,429.2 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 131.9 тэрбум төгрөг буюу 10.2 хувиар өссөн, харин 2016 оны жилийн эцсийн дүнтэй харьцуулахад 44.9 тэрбум төгрөг буюу 3 хувиар буурсан байна.

Тайлант хугацаанд зах зээлийн үнэлгээнд томоохон өсөлт гарсан компаниудаас дурдвал Таван толгой ХК 49.8 хувь буюу 71 тэрбум төгрөг, Говь ХК 16.5 хувь буюу 13 тэрбум төгрөг, Монгол шуудан ХК 10.3 хувь буюу 3 тэрбум төгрөг, Сүү ХК 5.3 хувь буюу 2.3 тэрбум төгрөгөөр өсжээ. Харин МИК холдинг ХК-ийн ЗЗҮ 16.3 хувь буюу 41.4 тэрбум төгрөг, АПУ ХК-ийнх 13.01 хувь буюу 38.3 тэрбум төгрөг, УБ БҮК ХК-ийнх 20.8 хувь буюу 12.4 тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

Зураг 1: Зах зээлийн үнэлгээ ба бодит ДНБ-ий өсөлт




*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо, ҮСХ*

Тайлант хугацаанд нийт ЗЗҮ-ний 90.3 хувийг 30 компани бүрдүүлсэн бөгөөд эдгээр компаниудын дийлэнх нь уул уурхай, аж үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа явуулж байна.

Тодруулбал, уул уурхайн салбарын өсөлт, бууралт дотоодын үнэт цаасны зах зээлийн үнэлгээнд шууд нөлөөлөв.

*Манай улсын хувьд хувьцааны хөрвөх чадварын түвшин бусад хөгжиж буй орнуудтай харьцуулахад доогуур байгаа ба үүнд хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудын хувьцаа хэт төвлөрсөн, компанийн засаглал, санхүүгийн тайлагнал, мэдээллийн ил тод байдал хангалтгүй, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл цөөн, олон нийтийн хөрөнгө оруулалт, хувьцааны талаарх мэдлэг, мэдээлэл дутмаг зэрэг хүчин зүйлс гол нөлөөг үзүүлж байна.*

Зураг 2: ЗЗҮ ба хөрвөх чадвар




*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

Үнэт цаасны зах зээлийн индексүүд: Тайлант хугацаанд ТОП-20 индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 13.3 хувиар, 2016 оны жилийн эцэстэй харьцуулахад 9.25 хувиар өсөж 12,679.1 нэгжид хүрсэн бол MSE ALL индекс өмнөх оны мөн үеэс 3.1 хувиар, 2016 оны жилийн эцсээс 4 хувиар өсөж 846 нэгжид хүрчээ.

Зураг 3: ТОП-20 индекс




*Эх сурвалж: "Монголын хөрөнгийн биржь" ХК*

### 2.1.2 ХАА-н гаралтай бараа, түүхий эдийн зах зээл

ХАА-н биржийн хөгжил: Монгол Улсын Их Хурлаас 2011 онд батлагдсан Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ЗГ-ын 30

дугаар тогтоол, Төрийн өмчийн хорооны 45 дугаар тогтоол гарч “Хөдөө аж ахуйн бирж” ТӨХХК-ийг үүсгэн байгуулж төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд болон гүйцэтгэх удирдлагыг томилсон. ХАА-н бирж нь свот болон үүсмэл гэрээний арилжааг зохион байгуулах, төлбөр тооцоог гүйцэтгэх, биржийн арилжаанд оролцогчдыг сургах, мэргэшүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бөгөөд хуулиар олгогдсон чиг үүргээ хэрэгжүүлэхдээ шударга, ил тод, нээлттэй байх зарчмыг баримталдаг.

Хөдөө аж ахуйн бирж нь анх 2013 оны 4 дүгээр сарын 05-ны өдрөөс хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эд арилжаалж эхэлсэн ба 2017 оны 1 дүгээр улирлын байдлаар буюу нийт 4 жилийн хугацаанд 703 удаагийн 1,883.0 тэрбум төгрөгийн арилжаа явуулжээ.

ХАА-н биржээр дамжин 2014 оны 1 дүгээр улиралд 53.7 тэрбум, 2015 оны 1 дүгээр улиралд 28.8 тэрбум, 2016 оны 1 дүгээр улиралд 21.3 тэрбум, 2017 оны 1 дүгээр улиралд 30.9 тэрбум төгрөгийн арилжаа  тус тус хийгджээ.

2017 оны 1 дүгээр улиралд арилжсан бараа, түүхий эдийн хэмжээг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 9.6 тэрбум төгрөг буюу 45 хувиар өссөн үзүүлэлттэй гарчээ.

Зураг 4: ХАА-н биржийн арилжаа /тэрбум төгрөгөөр/




*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

Бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтээс шалтгаалан 1 болон 4 дүгээр улирлуудад арилжааны хэмжээ буурдаг ба 2 болон 3 дугаар улирлуудад свот арилжаа идэвхэждэг.

## ХАА-н биржийн индекс

Зураг 5: MAPIX индекс




*Эх сурвалж: Хөдөө аж ахуйн биржс*

MAPIX индекс 2017 оны 1 улирлын байдлаар, 3 дугаар сарын 29 – ний өдөр хамгийн их буюу 795,358.7 нэгж байсан бол 1 дүгээр сарын 03-ны өдөр хамгийн бага буюу 492,981.1 нэгж байв.

## 2.2 ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ

Даатгалын зах зээлийн бүтэц: Тайлант хугацаанд нийт 271 даатгалын компани, зуучлагч, хохирол үнэлэгч, аудитын компани, актуарч, аудитор СЗХ-ноос олгосон тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрхийн үндсэн дээр үйл ажиллагаа явуулж байна. 2017 оны 1 дүгээр улирлын байдлаар хохирол үнэлгээний 1 компани хасагдсан бол даатгалын зуучлагч компани 1 нэмэгдсэн байна.

Зураг 6: Даатгалын зах зээлийн бүтэц

*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

Даатгалын зах зээлд өнөөгийн байдлаар ердийн даатгалын 15 компани, урт хугацааны даатгалын 1 компани, давхар даатгалын 1 компани үйл ажиллагаа явуулж байна. Харин

мэргэжлийн оролцогчдын хувьд 41 даатгалын зуучлагч компани байгаагаас давхар даатгалын зуучлагч 9, даатгалын хохирол үнэлэгч 30 компани, 3,039 даатгалын төлөөлөгчид тус тус СЗХ-ноос олгосон тусгай зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулж байна.

Түүнчлэн даатгалын компаниуд болон мэргэжлийн оролцогчдын нийтлэг эрх ашгийг хамгаалах зорилго бүхий төрийн бус байгууллагууд СЗХ-той санамж бичгийн хүрээнд хамтран ажилладаг. Эдгээр холбоодыг дурдвал, Албан журмын даатгагчдын холбоо, Монголын даатгагчдын холбоо, Монголын даатгалын зуучлагчдын холбоо, Монголын хохирол үнэлэгчдийн холбоо зэрэг юм.

Даатгалын компаниуд болон мэргэжлийн оролцогчдын санхүү нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа стандартын дагуу хөтлөгдөж буй эсэхэд хяналт тавих, баталгаажуулах үүднээс аудитын компаниудад СЗХ-ноос эрх олгодог. Одоогоор нийт 42 аудитын компани болон 126 аудиторт тус эрхийг олгоод байна.

Хүснэгт 1: Даатгалын салбарын мэргэжлийн оролцогчид

| Он | Ердийн даатгал | Урт хугацааны даатгал | Давхар даатгал | Даатгалын зуучлагч | Хохирол үнэлэгч | Актуарч | Аудитын компани | Аудитор | Нийт |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2007 | 15 | - | - | 2 | - | - | - | - | 17 |
| 2008 | 15 | 1 | - | 4 | - | 9 | - | - | 29 |
| 2009 | 17 | 1 | - | 5 | 2 | 10 | - | - | 35 |
| 2010 | 16 | 1 | - | 9 | 6 | 12 | - | - | 44 |
| 2011 | 16 | 1 | - | 8 | 9 | 13 | - | - | 47 |
| 2012 | 17 | 1 | - | 17 | 9 | 18 | 16 | 43 | 121 |
| 2013 | 16 | 1 | - | 20 | 14 | 15 | 22 | 69 | 157 |
| 2014 | 16 | 1 | - | 30 | 20 | 15 | 30 | 84 | 196 |
| 2015 | 15 | 1 | 1 | 37 | 27 | 15 | 40 | 124 | 260 |
| 2016 | 15 | 1 | 1 | 40 | 31 | 15 | 42 | 126 | 271 |
| 2017.I | 15 | 1 | 1 | 41 | 30 | 15 | 42 | 126 | 271 |

*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

2017 оны 1 дүгээр улирлын байдлаар “Монгол даатгал” ХХК-ийн нийт хөрөнгө ердийн даатгалын компаниудын нийт хөрөнгөд эзлэх хувь хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 1 хувиар буурч 17.7 хувьд хүрсэн боловч зах зээлд хамгийн өндөр хувийг эзэлсэн хэвээр байна. Нэр бүхий 3 даатгалын компани нийт хөрөнгийн хэмжээгээрээ тус тус ердийн даатгалын зах зээлийн 9 хувиас 13.6 хувийг эзэлж байна.

2016 оны мөн үед дээр дурдсан 4 даатгагч ердийн даатгалын зах зээлийн 47.5 хувийг эзэлж байсан бол уг үзүүлэлт энэ оны 1 дүгээр улиралд 3.3 хувиар өсөж, 50.8 хувь болов. Бусад ердийн даатгалын компаниудын хувьд зах зээлд эзлэх хувь хэмжээ ойролцоо түвшинд буюу 2.4-аас 6.3 хувийг, дунджаар 4.5 хувийг эзэлж байна.

Зураг 7: Ердийн даатгалын компаниудын зах зээлд эзлэх хувь




*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

Даатгалын гүнзгийрэлтийн түвшин: Даатгалын салбарын үндсэн үзүүлэлтүүд сүүлийн жилүүдэд өсөлттэй байгаа хэдий ч салбарын хөгжлийн гол хэмжүүр болох даатгалын гүнзгийрэлт буюу ДНБ-д эзлэх хураамжийн орлогын хувь хэмжээ олон улсын түвшинтэй харьцуулахад доогуур байна. 2017 оны 1 дүгээр улирлын байдлаар даатгалын гүнзгийрэлт 0.66 хувь байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 0.08 хувиар өссөн үзүүлэлт юм.

Олон улсын хандлагаас харахад урт хугацааны даатгалын гүнзгийрэлт ердийн даатгалаас илүү өндөр хувьтай байдаг бол манай орны хувьд нөхцөл байдал эсрэгээрээ байна. Европын болон Азийн зарим орнуудад урт хугацааны даатгалын гүнзгийрэлт 5 хувиас дээш, Өмнөд Африк болон Ирландад 101 хувиас дээш байхад манай орны хувьд сүүлийн жилүүдэд дунджаар 0.01 хувьтай байгаа юм. Харин OECD-ийн гишүүн орнуудын ердийн даатгалын гүнзгийрэлт 2015 оны байдлаар 4.4 хувь байхад манай орны хувьд тайлант хугацаанд 0.64 хувь байна.

Зураг 8: Даатгалын гүнзгийрэлтийн түвшин




*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

Нийт хөрөнгө: Тайлант хугацаанд нийт хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 19 хувиар өсөж 224.8 тэрбум төгрөгт хүрлээ. Давхар даатгалын компанийн нийт хөрөнгийн өсөлт бусад даатгалын төрөлтэй харьцуулахад хамгийн өндөр буюу 23.7 хувиар өсөж 36.2

[1] Эх сурвалж: OECD, "Дэлхийн даатгалын зах зээлийн хандлага", 2016

тэрбум төгрөг болов. Ердийн даатгалын компаниудын нийт хөрөнгө 19 хувиар өсөж 180.8 тэрбум төгрөг болж, салбарын нийт хөрөнгийн 80.5 хувийг эзэлж байгаа бол урт хугацааны даатгалын компанийн нийт хөрөнгийн хэмжээ 0.4 хувиар өсөж 7.7 тэрбум төгрөгөөр илэрхийлэгдэж байна.

Зураг 9: Даатгалын салбарын нийт хөрөнгө




*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

Нийт даатгалын компаниудын хөрөнгийн дундаж өсөлт 2016 оны 1 дүгээр улиралд 14 хувь байсан бол 2017 онд уг өсөлт 16 хувьтай байна. 2016 онд 1 дүгээр улирлын байдлаар нийт хөрөнгийн өсөлт 10 хувиас доош компанийн тоо хамгийн өндөр байсан бол 2017 онд салбарын хэмжээнд даатгалын компаниудын хөрөнгийн өсөлт сайжирч 10 хувиас 20 хувийн өсөлттэй компанийн тоо хамгийн олон байна.

Зураг 10: Даатгалын компанийн хөрөнгийн өсөлтийн тархалт




*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

Хураамжийн орлого: Даатгалын компаниуд энэ оны эхний улиралд нийт 37.5 тэрбум төгрөгийн хураамжийн орлоготой ажиллав. Үүнээс ердийн даатгалын компаниуд 36.6 тэрбум төгрөг, урт хугацааны даатгалын компани 0.4 тэрбум төгрөг, давхар даатгалын компани 0.5 тэрбум төгрөгийн хураамжийн орлого бүрдүүлэв. 2016 оны 1 дүгээр улиралд нийт хураамжийн орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад 23.4 хувийн бууралттай гарч байсан бол 2017 оны эхний улиралд уг үзүүлэлт 37.8 хувийн өсөлтийг үзүүлэв.

Зураг 11: Хураамжийн орлого




*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

Нөхөн төлбөр, давхар даатгалын хураамж: Даатгалын компаниудын нийт нөхөн төлбөрийн зардал 2017 оны 1 дүгээр улирлын байдлаар 8.8 тэрбум төгрөгт хүрч, нийт хураамжийн орлогын 23.5 хувийг эзлэв. Үүнээс ердийн даатгалын компаниудын нөхөн төлбөр 98.0 хувийг бүрдүүлж байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нөхөн төлбөрийн зардал 1.4 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Тайлант хугацаанд нийт 20.0 тэрбум төгрөгийн давхар даатгалын хураамжийг шилжүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 52.6 хувиар өсөж, нийт хураамжийн орлогын 53.4 хувийг эзэлж байна. Ердийн даатгалын компаниуд давхар даатгалд 19.8 тэрбум төгрөг, давхар даатгалын компани 214 сая төгрөг, урт хугацааны даатгалын компани 5.3 сая төгрөгийг зарцуулжээ.

Зураг 12: Нөхөн төлбөр, давхар даатгалын хураамж




*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

Нөөц сан: Даатгалын салбарын нийт нөөц сангийн хэмжээ 2017 оны 1 дүгээр улирлын байдлаар 105.4 тэрбум төгрөгт хүрсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 24.1 хувиар өссөн үзүүлэлт юм. 1 дүгээр улирлын харьцуулсан үзүүлэлтээс харахад 2011 оноос хойш нийт нөөц сангийн өсөлт тогтвортой, дунджаар 24 хувь байна.

Зураг 13: Нөөц сангийн хэмжээ, өсөлт




*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

Нөөц сангийн хөрөнгийн дийлэнх хувь нь арилжааны банкуудад хадгаламж болон хадгаламжийн сертификат хэлбэрээр байршиж байна.

## 2.3 БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

ББСБ-уудын эдийн засагт үзүүлэх нөлөө: 2017 оны 1 дүгээр улирлын байдлаар нэрлэсэн ДНБ болон нийт хөрөнгийн харьцаа 0.14 хувь байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 0.01 нэгжээр өссөн байна.

Өнөөгийн байдлаар арилжааны банкны зээл авах шаардлагыг хангаагүй, барьцаа хөрөнгөгүй иргэд, аж ахуй нэгжүүд ББСБ-уудаар үйлчлүүлдэг бөгөөд тэдгээр харилцагчид эрсдэл өндөртэй бүлэгт хамаарагдах тул зээлийн эрсдэлийн хэмжээ нэмэгдсэнээр өндөр хүүтэй зээл авах нөхцөл бүрддэг. Нөгөө талаас ББСБ-аас зээл хүсч буй харилцагчийн талаар тодорхой мэдээлэл байдаггүйн улмаас мэдээллийн тэгш бус байдалд (adverse selection) үндэслэн шийдвэр гаргах эрсдэл байдаг тул хүүгийн хэмжээ өндрөөр тогтоох хүчин зүйл болдог. Гэвч зээлийн өндөр хүү нь харилцагчийг зээлээ эргэн төлж чадахгүй байдалд хүргэдэг тул ББСБ-уудад зээлийн эрсдэл үүсгэх гол хүчин зүйл болдог.

Зураг 14: Нийт хөрөнгө ба ДНБ-ий харьцаа




*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

ББСБ ба харилцагчдын тоо: 2017 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт ББСБ-ын тоо 529-д хүрч өмнөх оны мөн үеэс 14 хувиар, өмнөх улирлаас 2.5 хувиар нэмэгдсэн. Харилцагчдын тоо 1.3

саяд хүрсэн нь цахим төлбөр тооцооны харилцагчдын бүртгэлийг нэмсэнтэй холбоотой болно. Монгол Улсын хэмжээнд 1.2 сая иргэн цахим төлбөр тооцоог үйл ажиллагаандаа ашиглаж байгаа нь санхүүгийн үйлчилгээг технологид суурилсан байдлаар хэрэглэгчдэд хүргэх нь оновчтойг илтгэж байна.

Харилцаа холбооны зохицуулах хорооноос[2] үүрэн холбооны хэрэглэгчдийн тоог 2016 онд 3.4 сая ба үүнээс ухаалаг гар утас хэрэглэгчдийн тоо 2.4 сая, интернет хэрэглэгчдийн тоо 2.7 сая гэж мэдээлсэн ба цаашид технологид суурилсан санхүүгийн үйлчилгээг хөгжүүлэхэд олон нийт харьцангуй сайн хэрэглээтэй байгаа нь давуу талтай.

Зураг 15: ББСБ ба харилцагчдын тоо




*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

ББСБ-уудын өөрийн хөрөнгө 635.3 тэрбум төгрөг ба нийт хөрөнгийн 80 хувийг эзэлж байна. Харин ББСБ-ууд болон арилжааны банкуудын хувь нийлүүлсэн хөрөнгийн харьцаа 42:58 тул ББСБ-ууд хадгаламж татдаггүй хэдий ч өөрсдийн хөрөнгөөр санхүүгийн үйлчилгээг хүргэж байгаа тогтолцоог бичил санхүүгийн үйлчилгээний хэлбэр лүү шилжүүлж хадгаламж татах, зээл олгох, бичил даатгалын үйлчилгээ явуулах байдлаар өргөжүүлснээр манай орны нийгэм, эдийн засагт ихээхэн ач холбогдолтой.

ББСБ-уудын зах зээлд эзлэх хувь: ББСБ-уудын тоо нэмэгдэж байгаа ч тайлант улиралд зах зээлд хамгийн өндөр хувийг эзэлдэг байсан нэг ББСБ-ын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон учраас бусад ББСБ-ууд зах зээлд ижил түвшинд байршиж байна.

Хүснэгт 2. ББСБ-уудын зах зээлд эзлэх хувь

| Зах зээлд эзлэх хувь | ББСБ-ын тоо /Нийт хөрөнгөөр/ | ББСБ-ын тоо /Нийт орлогоор/ |
|---|---|---|
| 3% - 4% | 1 | 2 |
| 2% - 2.99% | 7 | 2 |
| 1% - 1.99% | 7 | 7 |
| 0.5% - 0.99% | 21 | 8 |
| 0.3% - 0.49% | 41 | 21 |

[2] http://www.crc.gov.mn/k/35/23

| | | |
|---|---|---|
| 0.1% - 0.29% | 347 | 260 |
| 0.09% - аас доош | 105 | 193 |
| 0% | - | 34 |

*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

## 2.4 ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО

СЗХ-ны зохицуулалттай үйл ажиллагаа явуулж буй хадгаламж, зээлийн хоршоо нь 2017 оны 1 дүгээр улирлын байдлаар 282 байгаа ба үүнээс Улаанбаатар хотод 66 хувь, хөдөө орон нутагт 34 хувийг тус тус эзэлж байна. Хөдөө орон нутагт нийт 97 ХЗХ байгаагаас баруун бүсийн аймгуудад харьцангуй олон хоршоо үйл ажиллагаа явуулж буй бөгөөд баруун бүс дотроо Баян-Өлгий, Увс, Завхан аймгууд дийлэнх хувийн эзэлж байна.

Нийслэл Улаанбаатар хотод нийт хоршооны ихэнх нь ажиллаж байгаа бөгөөд 2014 оноос нийслэлийн төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх ХЗХ-д байгуулагдсанаар хоршоодын тоо эрс нэмэгдсэн.

Зураг 16: ХЗХ-дын тоо /бүс нутгаар/




*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

ХЗХ-дын тоо: 2017 оны 1 дүгээр улиралд ХЗХ-дын тоо өмнөх оны эцсээс Улаанбаатар, хөдөө орон нутаг тус бүр нэгээр нэмэгдэж өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 4.1 хувиар өсөн, нийт 282 ХЗХ үйл ажиллагаа явуулж байна. Гишүүдийн тоо 14.6 хувиар буюу 6,101-ээр нэмэгдэж 47,918 болсон байна.

ХЗХ-д олонтой аймагт ББСБ-уудын тоо цөөн байх бол ХЗХ-дын тоо цөөн байгаа аймагт ББСБ-ууд олон байх урвуу хамаарал ажиглагдав. Цаашид ХЗХ-дын тоог аймаг орон нутагт нэмэгдүүлснээр жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжих, хүртээмжийг дээшлүүлэх чухал алхам болох юм.

Зураг 17: ХЗХ-д ба гишүүдийн тоо /мянгаар/




*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

Эдийн засагт үзүүлэх нөлөө: Тайлант улиралд нийт хөрөнгийн хэмжээ 121.7 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 20 хувиар буюу 20.2 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. ХЗХ-дын нийт хөрөнгийн хэмжээ өнгөрсөн оны мөн үетэй адилаар нэрлэсэн ДНБ-ий 2.1 хувьтай тэнцүү байна.

Зураг 18: Нийт хөрөнгө ба ДНБ-ий өөрчлөлт




*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

# III. ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ

## 3.1 ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

### 3.1.1 Үнэт цаасны зах зээл

2017 оны 1 дүгээр улиралд "ҮЦТХТ" ХХК-д нийтдээ 890,780 данс, 140,165 холболтын данс бүртгэлтэй байна. Нийт дансыг бүтцээр нь үзвэл 886,091 дотоодын иргэн, 1,948 гадаадын иргэн, 2,562 дотоодын аж ахуйн нэгж, 179 гадаадын аж ахуйн нэгжийн данс тус тус байна. Тайлант хугацаанд үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид нийт 4,190 данс шинээр нээгдсэнээс 4,129 нь дотоодын иргэн, 28 нь гадаадын иргэн, 32 нь дотоодын аж ахуйн нэгж, 1 нь гадаадын аж ахуйн нэгжийн данс шинээр бүртгэгдсэн байна.

Тайлант хугацаанд "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн арилжааны үнийн дүнд гадаадын аж ахуйн нэгж болон иргэдийн эзлэх хувь 5.2 хувьтай байгаа бол дотоодын аж ахуйн нэгж болон дотоодын иргэдийн эзлэх хувь 94.7 хувьтай байна.

Зураг 19: Хөрөнгө оруулагчдын арилжаанд эзлэх хувь




*Эх сурвалж: "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК*

Гадаадын хөрөнгө оруулагчдын эзлэх хувь буурах хандлагатай байгаа нь зөвхөн Монгол Улсад бий болоод буй асуудал биш бөгөөд Азийн зарим орнуудад мөн тохиогоод байна. Иймд гадаад хөрөнгө оруулагч нар зугтах хандлагатай байгаа дээрх орнууд хөрөнгө оруулагч нарын итгэлийг сэргээхэд чиглэсэн бодлого баримталж байна.

Үнэт цаасны зах зээлийн оролцогчид: Тайлант хугацаанд СЗХ-ны үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэлд нийт 302 компани бүртгэлтэй байна.

Хүснэгт 3: Хувьцаат компанийн өмчийн хэлбэр, тоо

| Үнэт цаас гаргагчийн өмчийн бүтэц | Санхүүгийн зохицуулах хороо | "Монголын хөрөнгийн бирж" ХК | "ҮЦТХТ" ХХК |
|---|---|---|---|
| Төрийн өмчит | 31 | 21 | 35 |
| Төрийн өмчийн оролцоотой | 19 | 16 | 9 |
| Хувийн өмчит | 252 | 199 | 273 |
| **Нийт** | **302** | **236** | **317** |

2013-2016 оны хооронд СЗХ-оос хөрөнгийн биржийн нэр хүндийг өсгөх, үнэт цаасны бүртгэлийн ангиллыг шинэчлэх, СЗХ-ны бүртгэлийг бүртгэлийн хэлбэрээс зөвшөөрлийн хэлбэрт шилжүүлэх, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах хүрээнд өмч хөрөнгө нь үрэгдсэн, хувьцаа эзэмшигчдийн өмнө хуулиар хүлээсэн үүргээ сүүлийн 3-аас дээш жилийн хугацаанд тогтмол биелүүлээгүй компаниудын үнэт цаасыг бүртгэлээс хасах, хууль хяналтын байгууллагуудад шилжүүлэх хийгээд компанийн засаглал, санхүүгийн тайлагнал, мэдээллийн ил тод байдлыг сайжруулах зэрэг тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хүснэгт 4: Хувьцаат компанийн хувьцааны бүтэц

| Үнэт цаас гаргагчийн ангилал | 2015 он | 2016 он | 2017.I |
|---|---|---|---|
| Төрийн мэдлийн бус хувьцаа | 2,809,930 | 4,160,854 | 4,160,810 |
| Төрийн мэдлийн хувьцаа | 2,246,316 | 2,818,124 | 2,818,124 |
| Орон нутгийн оролцоотой | 29,046 | 29,046 | 29,046 |
| **Нийт** | **5,085,292** | **7,008,024** | **7,011,980** |
| Эрдэнэс Тавантолгой /Иргэн/ | 2,558,176 | 2,212,224 | 2,212,224 |
| Эрдэнэс Тавантолгой /ААН/ | 5,139 | 5,203 | 5,239 |
| Эрдэнэс Тавантолгой /Төр/ | 12,436,685 | 12,782,573 | 12,782,537 |
| **Нийт** | **15,000,000** | **15,000,000** | **15,000,000** |
| **Хаалттай ХК** | 172,753 | 174,958 | 214,449,600 |
| **Нийт** | **172,753** | **174,958** | **214,449,600** |

*Эх сурвалж: "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК*

Ашигт малтмалын тухай хуулийн 5.6-д заасны дагуу 15 стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа хуулийн этгээдийн хувьцааны 10 хувийг хөрөнгийн биржээр арилжаалах хуулийн шаардлагыг хэрэгжүүлэх нь үнэт цаасны зах зээл дээр шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний нийлүүлэлтийг нэмэгдүүлж, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын оролцоог тэлэх ач холбогдолтой бөгөөд дээрх ордын тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа хуулийн этгээдүүдээс нэр бүхий 4 /Багануур ХК, Шивээ овоо ХК, Таван толгой ХК, Дархан төмөрлөгийн үйлдвэр ХК/ нь хувьцаат компани хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд 62 ҮЦК СЗХ-оос олгосон тусгай зөвшөөрлийн хүрээнд үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж байгаагаас 2 нь үнэт цаасны арилжаа, 1 нь үнэт цаасны төлбөр тооцоо, 1 нь төвлөрсөн хадгаламж, 3 нь кастодиан банкны үйлчилгээ, 14 нь хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхэлж байна. Мөн хөдөө аж ахуйн биржийн арилжаа, зуучлалын чиглэлээр арилжаа эрхлэх 1, бараа, түүхий эдийн арилжааны зуучлалын үйл ажиллагаа эрхлэх 15 этгээд үйл ажиллагаа явуулж байна. СЗХ-оос олгосон тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж буй зохицуулалттай этгээдүүдийг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 5: Зохицуулалттай этгээдийн тоо

| Д/д | Зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэгч | Оролцогчдын тоо |
|---|---|---|
| **1** | Үнэт цаасны арилжаа эрхлэх | 2 |
| **2** | Үнэт цаасны төлбөр тооцооны | 1 |
| **3** | Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн | 1 |
| **4** | Хөрөнгө оруулалтын менежментийн | 14 |
| **5** | Брокер, дилер | 62 |
| **6** | Кастодиан банк | 3 |
| **7** | Андеррайтер /*давхардсан тоогоор*/ | 25 |
| **8** | Хөрөнгө оруулалтын зөвлөх /*давхардсан тоогоор*/ | 15 |
| | **Нийт** | **83** |
| **9** | Хөдөө аж ахуйн түүхий эдийн арилжаа эрхлэх | 1 |
| **10** | Хөдөө аж ахуйн түүхий эдийн брокер | 15 |
| **11** | Аудитын компани | 47 |
| **12** | Үнэлгээний компани | 20 |
| **13** | Хуулийн компани | 20 |

*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

### 3.1.2 ХАА-н гаралтай бараа, түүхий эдийн зах зээл

2017 оны 1 дүгээр улирлын байдлаар Хөдөө аж ахуйн биржийн гишүүн 13 брокерын компани үйл ажиллагаа явуулж байна. Тэдгээрээс 4 брокер хөдөө орон нутагт ажилладаг ба баруун бүсэд 3, зүүн бүсэд 1 брокер тус тус үйл ажиллагааг явуулж байна.

Зураг 20: Хөдөө орон нутгууд дахь брокеруудын байршил




*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

Харин үлдсэн 9 брокер Улаанбаатар хотод төвлөрөн ажилладаг бөгөөд нийслэлийн нийт 9 дүүргийн 4-т нь брокер, арилжааны зуучлагч /брокер/-ын үйл ажиллагаа эрхэлж байна.

Зураг 21: ХАА-н гаралтай бараа, түүхий эдийн арилжаа /бүтээгдэхүүнээр/




*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

Хөдөө аж ахуйн биржээр дамжин 8 бүтээгдэхүүн арилжаалагддагаас, тайлант үед нийт 4 төрлийн бүтээгдэхүүн арилжаалагдсан. Эдгээр нь ямааны ноолуур, хонины ноос, тэмээний ноос, болон завод ноос (ямааны болон хонины) болно. Бүтээгдэхүүн тус бүрийг арилжигдсан хэмжээгээр нь өмнөх оны мөн үетэй харьцуулан авч үзлээ. Үүнд ямааны ноолуур өмнөх оны мөн үеийнхээс 353 хувиар, завод ноос 15 хувиар тус тус өссөн бол хонины ноос 69 хувиар, тэмээний ноос 63 хувиар тус тус буурсан байна. Харин бодын хөөвөр 2017 оны 1 дүгээр улиралд арилжигдаагүй байна.

## 3.2 ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ

Даатгалын нягтралын үзүүлэлт буюу нэг хүнд ногдох хураамжийн орлогын харьцаа нь салбарын хүртээмж, эрэлтийг илэрхийлдэг. Хүн амын тоог жилд нэг удаа тооцдог тул даатгалын нягтралыг улирлаар тооцох боломжгүй юм. Иймд 2016 оны жилийн эцсийн байдлаар үзүүллээ.

Зураг 22: Даатгалын нягтрал /төгрөгөөр/




*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо, ҮСХ*

2015 оны жилийн эцэст нэг хүнд ногдох даатгалын хураамжийн хэмжээ 37,261.5 төгрөг байсан бол 2016 оны жилийн эцэст 561.3 төгрөгөөр буюу 1.5 хувиар буурч 36,700.1 төгрөг болов. Хураамжийн орлогын өсөлт хүн амын өсөлтөөс бага байсан нь энэ бууралтад нөлөөлөв.

Даатгалын нягтралыг ангиллаар авч үзвэл, нэг хүнд ногдох ердийн даатгалын хураамж 2.5 хувиар буурч 35,794.5 төгрөг болсон бол урт хугацааны даатгалын хураамж 67.4 хувиар өсөж 905.6 төгрөгт хүрсэн байна.

Зураг 23: Даатгалын компани болон зуучлагчдын салбаруудын байршил /аймгуудаар/




*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

Даатгалын үйлчилгээний хүртээмжийг илэрхийлэгч өөр нэгэн үзүүлэлт нь даатгалын компанийн салбар, зуучлагчдын тоо юм. Хөдөө орон нутагт даатгалын компани, зуучлагчийн нийт 285 салбар байгаа бөгөөд нэг аймагт дунджаар 14 салбар нэгж ногдож байна.

Зураг 24: Даатгалын компани болон зуучлагчдын салбаруудын байршил /дүүргээр/




*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

Тайлант хугацаанд Улаанбаатар хотын нийт дүүрэгт даатгалын компани болон зуучлагчийн 164 салбар нэгж бүртгэгдэв. Нийт салбар нэгжийн 81.1 хувь нь төвийн 5 дүүрэгт төвлөрсөн байна.

Түүнчлэн БНСУ болон БНХАУ-д тус тус нэг салбар төлөөлөгчийн нэгж үйл ажиллагаа явуулж байна.

## 3.3 БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

ББСБ-уудын тархалт: Монгол Улсын 21 аймгийн 20-д нь ББСБ-ийн үйлчилгээ тархсан байгаа боловч тооны хувьд хангалтгүй буюу зөвхөн аймгийн төвүүд дээр цөөн тоогоор үйл ажиллагаа явуулж байна. Харин Улаанбаатар хотын төвийн дүүргүүдэд маш ойрхон байршжээ.

Зураг 25. ББСБ-уудын тархалт




*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

ББСБ-ын үйлчилгээг хүртэх боломж: Монгол Улсын хэмжээнд 100,000 иргэнд 21, 1000 аж ахуй нэгжид 9 ББСБ ногдож байгаа бол энэ харьцаа Улаанбаатар хотод 41, 12, хөдөө орон нутагт 6, 4 байна.

Зураг 26. ББСБ-ын тоо /аймаг, дүүргээр/







*х сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

Зээлийн хэмжээ: 2017 оны 1 дүгээр улирлын байдлаар ББСБ-уудаас зээл авсан 58,923 зээлдэгч байгаа ба улсын хэмжээнд зээлдэгч ба хүн амын тооны харьцаа 1.9 хувь, нэг хүнд ногдож буй зээлийн хэмжээ 160.0 мянган төгрөг байна.

Улаанбаатар хотын хэмжээнд зээлдэгч ба хүн амын тооны харьцаа 3.8 хувь, нэг хүнд ногдож буй зээлийн хэмжээ 8.8 сая төгрөг байна.

Зураг 27. Зээлдэгчдийн тоо /дүүргээр/




*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

Аймгуудын хэмжээнд зээлдэгч ба хүн амын тооны харьцаа 0.2 хувь, нэг хүнд ногдож буй зээлийн хэмжээ 9,000.0 төгрөг байна.

Зураг 28. Зээлдэгчдийн тоо /аймгаар/




*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

## 3.4 ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО

ХЗХ-дын тоо тодорхой хэмжээнд өссөөр байгаа хэдий ч байршлын хувьд жигд тархсанаар хүртээмжийг жигд бий болгоно. Хүртээмж нь чухал үзүүлэлт бөгөөд үүнийг 100 ААН-д ногдох болон 10,000 хүнд ногдох ХЗХ-дын тоогоор илэрхийлж болно.

Улаанбаатар хотод нийт 185 ХЗХ, 7 салбар төлөөлөгчийн хамтаар үйл ажиллагаа эрхэлж байна. Хүртээмжийн үзүүлэлтээр нийслэл хотод Багахангай, Багануур дүүрэг 100 ААН-д ногдох ХЗХ-

дын тоогоор хамгийн сайн байгаа бол Баянгол, Баянзүрх дүүрэг хамгийн бага байна. Харин 10,000 хүнд ногдох ХЗХ-дын тоо мөн адил Багахангай, Багануур дүүрэгт сайн үзүүлэлттэй байна. Багахангай, Багануур дүүргийн ХЗХ-дын тоо бусад дүүргээс харьцангуй цөөн байхад хүртээмжийн үзүүлэлт сайн байна. Учир нь тухайн дүүрэгтэй харьцуулагдаж буй ААН болон хүн амын тоо бага байгаатай холбоотой.

Зураг 29: ХЗХ-дын хүртээмжтэй байдал /дүүргүүдээр/




*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

Монгол Улсын нийт ХЗХ-дын 34 хувь нь ажиллаж буй аймаг, орон нутгийн хүртээмжийг бүсээр ангилж харуулсан бөгөөд нийслэл хотоос илүү жигд тархсан хандлага ажиглагдаж байна. 100 ААН-д ногдох ХЗХ болон 10,000 хүнд ногдох ХЗХ-дын тоогоор баруун, зүүн бүс илүү хүртээмж сайтай байна.

Зураг 30: ХЗХ-дын хүртээмжтэй байдал /бүсээр/




*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

ХЗХ-дын тооны өсөлт: Тайлант улиралд өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт ХЗХ-дын тоо 4.1 хувийн өсөлт үзүүлсэн бөгөөд өмнөх улирлаас 0.7 хувиар өссөн байна. ХЗХ-дын тоо сүүлийн гурван жилийн хугацаанд огцом өсөхөд нийслэл Улаанбаатар хотын ХЗХ-дын тоо гол нөлөө үзүүлсэн буюу нийслэлийн төсөл хөтөлбөрөөр байгуулагдсан ХЗХ-дын тоо шууд нөлөө үзүүлжээ.

Зураг 31: ХЗХ-дын тоо өсөлтийн хувь




*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

# IV. БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ

## 4.1 ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

### 4.1.1 Үнэт цаасны зах зээл

Үнэт цаасны зах зээлийн нийлүүлэлт: 2017 оны 1 дүгээр улиралд “Монголын хөрөнгийн биржь” ХК-аар дамжуулан нийт 138 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий арилжаа хийгдсэн нь өмнөх оны мөн улиралтай харьцуулахад 1.78 дахин их байна. Нийт арилжааны 3.6 хувийг хувьцаа, 86.4 хувийг ЗГҮЦ-ны анхдагч арилжаа, 9.9 хувийг ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжаа тус тус эзлэв.

Хүснэгт 6: Үнэт цаасны арилжааны үзүүлэлт

| Үнэт цаасны төрөл | | Арилжигдсан тоо хэмжээ /сая ширхэг/ | Арилжааны үнийн дүн /тэрбум төгрөг/ |
|---|---|---|---|
| Хувьцаа | Хоёрдогч зах зээл | 28.9 | 5.0 |
| ЗГҮЦ | Анхдагч зах зээл | 1.3 | 119.5 |
| | Хоёрдогч зах зээл | 0.142 | 13.7 |

*Эх сурвалж: “Монголын хөрөнгийн биржь” ХК*

Хувьцааны арилжаа: “Монголын хөрөнгийн биржь” ХК-ийн 62 удаагийн арилжаагаар 28.9 сая ширхэг хувьцааг 5.0 тэрбум төгрөгөөр арилжаалсан байна.

Зураг 32: Хувьцааны арилжаа /тэрбум төгрөгөөр/




*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

Тендер саналын арилжаагаар нэр бүхий нэг хувьцаат компанийн 109.9 мянган ширхэг хувьцааг 30.0 сая төгрөгөөр арилжсан байна.

СЗХ-оос үнэт цаасны зах зээлд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, өөрийгөө зохицуулах байгууллагын тогтолцоог хөгжүүлэх зорилгоор үнэт цаасны бүртгэлийн журамд зохицуулалтын өөрчлөлт хийснээр СЗХ болон биржийн чиг үүргийн давхардлыг бууруулж, компаниуд хөрөнгийн биржийн бүртгэлд бүртгүүлж, урт хугацааны санхүүжилтийг татах орчныг улам хялбаршуулсан алхам болоод байна.

Засгийн газрын үнэт цаас /ЗГҮЦ/-ны арилжаа: 2014 оны 11 дүгээр сараас “Монголын хөрөнгийн бирж” ХК-иар Засгийн газрын жижиглэнгийн үнэт цаас арилжаалагдаж эхэлснээс хойш нийт 1,049 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий үнэт цаасыг анхдагч зах зээл дээр арилжаалсан байна.

2017 оны 1 дүгээр улирлын байдлаар ЗГҮЦ-ны анхдагч зах зээлийн арилжаа 11 удаа явагдаж 12, 28, 39, 52, 104, 156 долоо хоногийн хугацаатай нийт 1.3 сая ширхэг үнэт цаасыг 119.5 тэрбум төгрөгөөр арилжаалсан байна. Харин ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл дээр 142 мянган ширхэг үнэт цаас 13.7 тэрбум төгрөгөөр тус тус арилжаалагдсан байна.

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа: Өнгөрөгч онд “МИК ОССК” ХХК-ийн үүсгэн байгуулсан “МИК актив найм ТЗК” ХХК, “МИК актив ес ТЗК” ХХК, “МИК актив арав ТЗК” ХХК, “МИК актив арван нэг ТЗК” ХХК гэсэн дөрвөн тусгай зориулалтын компанийн нийт 7730 зээлдэгчдийн зээлийн багц бүхий 501.2 тэрбум төгрөгийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгэсэн бол 2017 оны 1 дүгээр улиралд хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас нэмж бүртгээгүй байна.

Хүснэгт 7: Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас /тэрбум төгрөгөөр/

| ХБҮЦ гаргагч | Нийт гаргасан үнэт цаас | "ҮЦТХТ" ХХК-д бүртгэгдсэн | Зээлдэгчийн тоо |
|---|---|---|---|
| “МИК актив нэг ТЗК” ХХК | 328.1 | 322.9 | 6,658 |
| “МИК актив хоёр ТЗК” ХХК | 224.8 | 222.1 | 5,290 |
| “МИК актив гурав ТЗК” ХХК | 328.5 | 324.6 | 6,593 |
| “МИК актив дөрөв ТЗК” ХХК | 459.4 | 452.3 | 9,510 |
| “МИК актив тав ТЗК” ХХК | 301.2 | 294.3 | 5,805 |
| “МИК актив зургаа ТЗК” ХХК | 267.8 | 261.7 | 5,188 |
| “МИК актив долоо ТЗК” ХХК | 299.6 | 293.8 | 5,414 |
| “МИК актив найм ТЗК” ХХК | 189.8 | 186.3 | 3,291 |
| “МИК актив ес ТЗК” ХХК | 137.5 | 137.2 | 1,719 |
| “МИК актив арав ТЗК” ХХК | 103.0 | - | 1,585 |
| “МИК актив арван нэг ТЗК” ХХК | 70.9 | - | 1,135 |
| **Нийт** | **2,710.6** | **2,495** | **52,188** |

*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

2017 оны 1 дүгээр улирлын байдлаар үндсэн ба хүүгийн төлбөр төлөгдсөн “МИК Актив Нэг” бондоос 68,602 ширхэг, “МИК Актив Хоёр” бондоос 45,534 ширхэг, “МИК Актив Гурав” бондоос 61,738 ширхэг, “МИК Актив Дөрөв” бондоос 91,560 ширхэг, "МИК Актив Тав” бондоос 52,809 ширхэг, "МИК Актив Зургаа” бондоос 44,912 ширхэг, “МИК Актив Долоо” бондоос 41,403 ширхэг, “МИК Актив Найм” бондоос 32,082 ширхэг, “МИК Актив Ес” бондоос 15,785 ширхэгийг тус тус хасаж, үндсэн бүртгэлд өөрчлөлт оруулсан.

### 4.1.2 ХАА-н гаралтай бараа, түүхий эдийн зах зээл

2013 оны 4 дүгээр сард биржээр дамжин зөвхөн нэг төрлийн түүхий эд буюу ямааны ноолуур арилжаалагддаг байсан бол 2017 оны 1 дүгээр улирлын байдлаар бараа бүтээгдэхүүний төрөл нэмэгдэж 8 төрлийн хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эд арилжаалагддаг болсон байна.

Үүнд: ямааны ноолуур, хонины ноос, тэмээний ноос, завод ноос, бодын хөөвөр, хүнсний буудай болон тосны ургамал зэрэг багтдаг. Завод ноос нь адууны, хонины, ямааны, сарлагийн, тэмээний гэж 5 ангилагддаг бол бодын хөөвөр нь сарлагийн, адууны, үхрийн гэсэн 3 ангилалд хуваагддаг.

2017 оны 1 дүгээр улирлын байдлаар эдгээр 8 төрлийн түүхий эдээс нийт 4 төрлийн бүтээгдэхүүн арилжаалагдсан ба тэдгээр нь ямааны ноолуур, хонины ноос, тэмээний, болон завод ноос болно. Үүнд, завод ноосноос зөвхөн ямааны болон хонины завод ноос арилжаалагдсан байна.

2017 оны 1 дүгээр улиралд арилжигдсан хэмжээгээрээ ямааны завод ноос хамгийн их буюу 1,051.6 тонн арилжаалагдаж, харин тэмээний ноос хамгийн бага буюу 27.8 тонн арилжаалагдсан байна. Харин арилжааныхаа дүнгээр мөн ямааны завод ноос 14.9 тэрбум төгрөг буюу нийт арилжааны 48 хувийг эзэлж байсан бол тэмээний ноос 131 сая төгрөг буюу нийт арилжааны 1 хүрэхгүй хувийг эзэлсэн байна.

Хүснэгт 8: ХАА-н биржийн арилжааны хэмжээ, дүн

| Д/д | Барааны нэр | Барааны хэмжээ /тонн/ | Арилжааны дүн /тэрбум төгрөг/ | Эзлэх хувь /арилжааны дүнгээр/ |
|---|---|---|---|---|
| 1 | Ямааны ноолуур | 163.6 | 13.8 | 44.8 |
| 2 | Хонины ноос | 909.5 | 1.3 | 4.2 |
| 3 | Тэмээний ноос | 27.8 | 0.131 | 0.4 |
| 4 | Завод ноос | | | |
| 4.1 | Ямааны завод ноос | 1051.6 | 14.9 | 48.3 |
| 4.2 | Хонины завод ноос | 517.8 | 0.691 | 2.2 |
| **Нийт** | | **2670.3** | **30.8** | **100** |

*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

## 4.2 ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ

Даатгалын зах зээл дээр ердийн, урт хугацааны болон давхар даатгалын нийт 24 хэлбэрийн даатгалын бүтээгдэхүүн арилжаалагдаж байна. Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалаас бусад бүх хэлбэрийн даатгал нь сайн дурын үндсэн дээр хийгдэж байгаа билээ.

Тайлант хугацаанд даатгалын зах зээлийн хэмжээнд нийт 37.5 тэрбум төгрөгийн хураамжийн орлоготой ажилласнаас ердийн даатгал 36.6 тэрбум төгрөг буюу 97.6 хувь, урт хугацааны даатгал 396.4 сая төгрөг буюу 1.1 хувь, давхар даатгал 504.4 сая төгрөг буюу 1.3 хувийг бүрдүүлэв. Харин нийт нөхөн төлбөрийн зардалд ердийн даатгал 8.6 тэрбум төгрөг буюу 98 хувь, урт хугацааны даатгал 176.8 сая төгрөг буюу 2 хувийг эзэлж байна.

Даатгалын нийт хураамжийн орлогын бүтцэд хөрөнгийн даатгал 36.3 хувь, жолоочийн хариуцлагын албан журмын даатгал 16.5 хувь, агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал 12.9 хувь, авто тээврийн хэрэгслийн даатгал 9.6 хувь, хариуцлагын даатгал 8.8 хувь, гэнэтийн осол эмчилгээний зардлын даатгал 6.9 хувийг эзэлж

байгаа бөгөөд үлдсэн 6.7 хувийг ердийн даатгалын бусад хэлбэрүүд, 1.1 хувийг урт хугацааны даатгал, 1.3 хувийг хөдөө аж ахуйн давхар даатгал тус тус эзэлж байна.

Даатгалын нийт нөхөн төлбөрийн бүтцэд жолоочийн хариуцлагын албан журмын даатгал 49.9 хувь, авто тээврийн хэрэгслийн даатгал 24.1 хувь, гэнэтийн осол эмчилгээний зардлын даатгал 11.3 хувь, санхүүгийн даатгал 4.7 хувь, хөрөнгийн даатгал 4.3 хувийг эзэлж байгаа бөгөөд үлдсэн 3.7 хувийг бусад ердийн даатгалын хэлбэрүүд, 2 хувийг урт хугацааны даатгал тус тус эзэлж байна.

Даатгалын зуучлагчид: 2017 оны 1 дүгээр улиралд тусгай зөвшөөрөл авсан 41 даатгалын зуучлагч бүртгэгдээд байна. Даатгалын нийт хураамжийн орлогын 15.3 хувийг буюу 5.8 тэрбум төгрөгийг зуучлалын компаниуд бүрдүүлэв. Харин тайлант жилд даатгалын зуучлалын компаниуд 10.4 тэрбум төгрөгийн нийт орлоготой ажилласнаас даатгалын зуучлалын үйл ажиллагаа явуулж буй 8 банк зуучлагчдын хураамжийн орлогын 36.8 хувь, бусад зуучлагчид 63.2 хувийг бүрдүүлжээ.

Зураг 33: Нийт зуучлагчдын даатгалын хураамжийн орлого /бүтцээр/

*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

Нийт зуучилсан даатгалын хураамжийн орлогод хөрөнгийн даатгал 40.2 хувь, жолоочийн хариуцлагын албан журмын даатгал 24.3 хувь, зээлийн даатгал 11.3 хувь, авто тээврийн хэрэгслийн даатгал 10.1 хувь, гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал 4.8 хувь, эрүүл мэндийн даатгал 3.2 хувь, санхүүгийн даатгал 2.2 хувь, даатгалын хэлбэрүүд бусад 3.9 хувийг тус тус эзэлсэн.

Даатгалын төлөөлөгч: Тайлант хугацаанд даатгалын төлөөлөгчид нийт хураамжийн орлогын 14.9 хувь буюу 5.6 тэрбум төгрөгийг бүрдүүлжээ.

Даатгалын төлөөлөгчөөр дамжин орсон хураамжийн орлогод жолоочийн хариуцлагын даатгал 31.0 хувь, хөрөнгийн даатгал 25.7 хувь, авто тээврийн хэрэгслийн даатгал 18.6 хувь, хариуцлагын даатгал 10.0 хувь, гэнэтийн осол, эмчилгээний даатгал 8.4 хувь, санхүүгийн даатгал 3.5 хувь, даатгалын хэлбэрүүд бусад 2.8 хувийг тус тус эзэлж байна.

Зураг 34: Даатгалын төлөөлөгчөөр дамжиж орсон хураамжийн орлого




*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

Даатгалын хохирол үнэлэгчид: 2017 оны 1 дүгээр улиралд даатгалын хохирол үнэлэгчид 3.6 тэрбум төгрөгийн хохирол үнэлж, 148.6 сая төгрөгийн орлоготой ажиллав.

Даатгалын хохирол үнэлгээний орлогод жолоочийн хариуцлагын албан журмын даатгал 65.7 хувь, авто тээврийн хэрэгслийн даатгал 20.6 хувь, авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал /сайн дурын/ 10.8 хувь, хөрөнгийн даатгал 2.8 хувийг тус тус эзэлж байна.

Зураг 35: Даатгалын хохирол үнэлгээний орлого

*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

## 4.3 БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

ББСБ-ууд 1 дүгээр улиралд 45.2 тэрбум төгрөгийн орлого олсноос 41.8 тэрбум төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлоготой ажиллажээ. Тайлант улиралд зээлийн хүүгийн орлого хамгийн өндөр буюу 88.2 хувийг эзэлж байгаа бол шинээр нэмэгдсэн үйлчилгээний орлого болох картын үйлчилгээний орлого 0.004 хувь байна.

Зураг 36. ББСБ-ын бүтээгдэхүүн, үйлчилгээний орлого




*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

## 4.4 ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО

ХЗХ-дын бүтээгдэхүүн үйлчилгээнээс олсон орлого: Тайлант улиралд 282 ХЗХ-ны нийт хүүгийн орлого 6.4 тэрбум төгрөгт хүрч, үүнээс хамгийн их хувийг эзэлж буй зээлийн хүү 95.1 хувь буюу 6.1 тэрбум төгрөгийн орлого оруулсан бол бусад орлогын нийлбэр 314.4 сая төгрөг гарав. Харин зээлийн хүүгийн орлогын буцаалт 18.2 сая төгрөг болсон байна.

Зураг 37: ХЗХ-дын бүтээгдэхүүн үйлчилгээнээс олсон орлого




*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

ХЗХ-дын бүтээгдэхүүн үйлчилгээнээс гарсан зардал: Тайлант улиралд нийт хүүгийн зардал 3.5 тэрбум төгрөг байна. Үүнээс хадгаламжийн хүүгийн зардал 97.1 хувийг эзлэх бөгөөд бусад зардлын нийлбэр 101.7 сая төгрөг бол хүүгийн зардлын буцаалт 527 мянган төгрөг байна.

Зураг 38: ХЗХ-дын бүтээгдэхүүн үйлчилгээнээс гарсан зардал




*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

# V. АШИГТ АЖИЛЛАГАА

# V. АШИГТ АЖИЛЛАГАА

## 5.1 ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

### 5.1.1 Үнэт цаасны зах зээл

Мэргэжлийн зуучлагч ҮЦК /брокер, дилер, андеррайтер/-иудын өнөөгийн нөхцөл байдал: 2017 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт ҮЦК-иудын тоо 62 байгаа нь хөрөнгө оруулагчдын хувьд хангалттай хэмжээнд хүрсэн хэдий ч, санхүүгийн хувьд чадавхтай, үнэт цаасны арилжаанд идэвхтэй оролцдог, холбогдох хууль тогтоомж болон Хорооноос тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж ажилладаг компаниуд цөөн байгаа тул хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, мэргэжлийн оролцогч байгууллагуудыг чадавхжуулах замаар үнэт цаасны арилжааны хэмжээ, хөрвөх чадвар болон гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлага тулгарч байна.

Хүснэгт 9: Нийт хөрөнгө /тэрбум төгрөгөөр/

| Д/д | Үндсэн үзүүлэлтүүд | 2015 он | 2016 он | 2017.I | Өсөлт/бууралт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Эргэлтийн хөрөнгө | 47.5 | 71.6 | 70.2 | -1.9% |
| 2 | Эргэлтийн бус хөрөнгө | 20.4 | 19.7 | 18.9 | -4.0% |
| 3 | **Нийт хөрөнгө** | **68.0** | **91.3** | **89.1** | **-3.4%** |
| 4 | Өр төлбөр | 6.4 | 24.5 | 20.5 | -17% |
| 5 | Эздийн өмч | 61.6 | 66.8 | 68.6 | 2.7% |
| 6 | **Нийт пассив** | **68.0** | **91.3** | **89.1** | **-3.4%** |

*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

2017 оны 1 дүгээр улирлын байдлаар тайлангаа ирүүлсэн 53 брокер, дилерийн компаниас нэр бүхий 19 ҮЦК нь ашигтай, 34 ҮЦК нь алдагдалтай, 8 ҮЦК тухайн хугацаанд үйл ажиллагаа явуулаагүй байдалтай байна. Тайлант хугацаанд нийт компаниудын актив хөрөнгийн хэмжээ 3.4 хувиар, өр төлбөрийн хэмжээ 17 хувиар буурсан байна.

Хүснэгт 10: Нийт орлого /сая төгрөгөөр/

| Д/д | Орлогын хураангуй тайлан | 2016 он | 2017.I улирал |
|---|---|---|---|
| 1 | Үйл ажиллагааны орлого | 5,492.1 | 2,178.4 |
| 2 | Ногдол ашгийн орлого | 493.0 | 25.5 |
| 3 | Борлуулалт маркетингийн болон ерөнхий удирдлагын зардал | 6,097.5 | 1,792.5 |
| 4 | Ажиллагчдын цалингийн зардал | 2,778.2 | 974.4 |
| 5 | Албан татвар, төлбөр, хураамжийн зардал | 847.6 | 245.0 |
| 6 | Санхүүгийн зардал | 588.0 | 836.5 |
| 7 | Бусад зардал | 82.3 | 21.8 |
| 8 | Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз) | 641.3 | -59.6 |
| 9 | Бусад ашиг (алдагдал) | -384.0 | -11.2 |
| 10 | **Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)** | **1,134.5** | **-29.9** |
| 11 | Орлогын татварын зардал | 117.9 | 22.4 |
| 12 | **Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)** | **1,016.6** | **-52.4** |

*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

Үнэт цаасны зах зээлд брокер, дилер, андеррайтерийн компаниудын тоо /давхардсан тоогоор/ 2010-2012 оны хооронд 95 болж огцом өссөн. Үүнд төрөөс “Эрдэнэс таван толгой” ХК-ийн 1072 ширхэг хувьцааг Монгол Улсын иргэн бүрд үнэ төлбөргүй эзэмшүүлэх шийдвэр гаргасан нь үнэт цаасны зах зээлд мэргэжлийн зуучлагчид болох брокер, дилерийн компаниудын тоо огцом өсөхөд хүргэсэн.

Зураг 39: ҮЦК-иудын тоо /брокер, дилер/




*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

Хэдийгээр үнэт цаасны зах зээлд брокер, дилерийн компанийн тоо нэмэгдсэн ч, мэргэжлийн өндөр түвшинд үйл ажиллагаа явуулах мэргэжлийн зуучлагчид бус, харин эсрэгээр үнэт цаасны арилжаанд оролцдоггүй, идэвхтэй үйл ажиллагаа явуулдаггүй, холбогдох хууль тогтоомж, гэрээгээр хүлээсэн үүрэг, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангадаггүй компаниудын тоо нэмэгдсэн бөгөөд үүнийг дагаад хувьцааны үнэ ханшийг зохиомлоор өсгөх, бууруулах, зах зээлд худал мэдээлэл тараах зэрэг зөрчлийг зарим нэр бүхий компаниуд гаргах болсон нь манай улсын хөрөнгийн зах зээлд итгэх хөрөнгө оруулагчдын оролцоо, идэвхийг бууруулахад нөлөөлсөн.

Үүнтэй холбоотойгоор СЗХ-оос 2013-2015 оны хооронд мэргэжлийн зуучлагч байгууллагуудын үйл ажиллагаа, санхүү, өөрийн хөрөнгө, хүний нөөцийн байдалд тавих газар дээрх болон зайны хяналт, шалгалтыг эрчимжүүлэн тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага хангаагүй компаниудын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлж ирсэн.

## 5.2 ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ

2017 оны 1 дүгээр улиралд даатгалын компаниудын нийт татварын дараах цэвэр ашиг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 75 хувиар буурч, 877 сая төгрөгт хүрэв. Ердийн даатгалын компаниуд 2016 оны 1 дүгээр улиралд 3.5 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж байсан бол тайлант хугацаанд 186.4 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллажээ. Тайлант хугацаанд ердийн даатгалын компаниудын үйл ажиллагааны зардал 32.4 хувиар, даатгалын гэрээний зардал 2.1 дахин өссөн нь татварын дараах цэвэр ашгийг бууруулав.

Зураг 40: Цэвэр ашиг




*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

*Жич: 2016 оны 1 дүгээр улирлын татварын дараах цэвэр ашгийн нийт дүнд давхар даатгалын цэвэр ашгийн дүн ороогүй болно.*

Голлох харьцаанууд: Хохирол нөхөлтийн харьцаа тайлант улиралд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад өссөн үзүүлэлттэй байв. Энэ нь нийт нөхөн төлбөрийн зардал 1.4 хувиар, орлогод тооцсон хураамж 4.6 хувиар буурсантай холбоотой юм.

Сүүлийн жилүүдэд даатгагчид үйл ажиллагааны зардлыг хамгийн оновчтой түвшинд хүргэхийг зорих болсон нь зардлын харьцааг сайжрахад түлхэц өгч байна. 2015 оны 1 дүгээр улиралтай харьцуулахад зардлын харьцаа 61.2 хувиас 48 хувь хүртлээ буурчээ. Даатгалын компаниуд зардлын удирдлагаа сайжруулан, өсөлтийг дэмжих шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд нэвтрүүлснээр энэхүү харьцааг цаашид ч бууруулах боломжтой юм.

Салбарын хэмжээнд зардлын хосолсон харьцааг авч үзвэл нийт орлогод тооцсон хураамжийн орлогын 97.4 хувьтай тэнцэж байна. Даатгалын компаниуд 2013 оноос 2015 онуудад даатгалын бус орлогоос дээрх үндсэн зардлуудаа нөхөж байсан бол сүүлийн 2 жилд үндсэн орлогоос санхүүжүүлж байна.

Даатгалын салбарын цэвэр ахиуц ашгийн харьцаа тайлант хугацаанд буурсан үзүүлэлттэй байлаа. 2016 оны 1 дүгээр улиралд цэвэр ахиуц ашиг 12.8 хувьтай байсан бол 2017 оны 1 дүгээр улиралд 2.3 хувь байна.

Зураг 41: Цэвэр ахиуц, хосолсон харьцаа




*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

Ашигт ажиллагааны коэффициент: Салбарын өөрийн хөрөнгийн өгөөж 2009 оны 1 дүгээр улиралд хамгийн өндөр буюу 12.6 хувь байсан бол 2014 онд уг үзүүлэлт буурч 0.7 хувьд хүрсэн билээ. Гэвч тайлант хугацаанд өөрийн хөрөнгийн өгөөж дахин буурч, 0.8 хувийн үзүүлэлттэй байв.

Нийт хөрөнгийн өгөөж болон өөрийн хөрөнгийн өгөөжийн график ижил чиглэлтэй байна. 2009 онд өөрийн хөрөнгийн өгөөж хамгийн өндөр түвшиндээ хүрч байсан бол нийт хөрөнгийн өгөөж мөн адил хамгийн өндөр түвшин болох 4.1 хувьд хүрч байв. Харин 2014 онд нийт хөрөнгийн өгөөж хамгийн доод цэгтээ буюу 0.3 хувьд хүрсэн боловч дараах 2 жилд сэргэсэн. Харин 2017 оны 1 дүгээр улирлын байдлаар 0.4 хувь байна.

Зураг 42: Нийт хөрөнгө, өөрийн хөрөнгийн өгөөж




*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

## 5.3 БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

ББСБ-ын салбарын хэмжээнд нийт хөрөнгийн өгөөж 2.4 хувь, өөрийн хөрөнгийн өгөөж 1.8 хувь байгаа ба 2012 оны 1 дүгээр улирлаас өсөж эхэлсэн нийт хөрөнгийн болон өөрийн хөрөнгийн өгөөж тайлант улиралд өмнөх оны мөн үеэс 0.8 болон 0.4 нэгжээр тус тус буурлаа. Гэвч зах зээлд ББСБ-ын үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн тоо нэмэгдсээр байна.

Зураг 43: Хөрөнгийн өгөөж




*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

ББСБ бүрийн хөрөнгийн өгөөжийг тооцоход нийт ББСБ-ын 47.0 хувь нь 1 хувиас 10 хувийн өгөөжтэй ажилласан ба өмнөх оны мөн үеэс 3.8 нэгжээр буурсан нь тэдгээрийн ашгийн түвшин багассантай холбоотой.

Зураг 44: ББСБ тус бүрийн хөрөнгийн өгөөж




*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

## 5.4 ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО

ХЗХ-дын үр ашигт байдал: Тайлант улиралд 282 ХЗХ-ны нийт орлого өмнөх оны мөн үеэс 14 хувиар буюу 856 сая төгрөгөөр нэмэгдэж 6.9 тэрбум төгрөгт хүрсэн бол зардал 18 хувиар өсөж 6.5 тэрбум төгрөгт хүрсэн. Харин нийт ашиг 138 сая төгрөгөөр буурч 484 сая төгрөгт хүрсэн ба нийт зардал өссөнтэй холбож болно.

Зураг 45: ХЗХ-дын ашигт ажиллагаа /тэрбум төгрөгөөр/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

СХЗ-оос төсөл хөтөлбөрийг дамжуулан хэрэгжүүлэх зөвшөөрөл авч, “Бичил бизнесийг дэмжих Нийслэлийн хөтөлбөр"-т хамрагдсан 123 ХЗХ байгаагаас 118 ХЗХ нь уг хөтөлбөрийг батлагдсанаас хойш шинээр байгуулагдсан ба хөтөлбөрөөс нийт 11.5 тэрбум төгрөгийн зээлийн санхүүжилтийг авсан байна.

Тайлант жилд дээрх 118 ХЗХ-оос 49 ХЗХ нь 160 сая төгрөгийн алдагдалтай ажилласан нь салбарын нийт алдагдлын 33.1 хувьтай тэнцэж байна. Мөн 4 ХЗХ ашиг болон алдагдалгүй, 65 ХЗХ 52.4 сая төгрөгийн ашигтай ажилласан байна. Тус ХЗХ-дын нийт хүүгийн орлого 568.5 сая төгрөг, үйл ажиллагааны зардал 676.2 сая төгрөг, тайлант үеийн ашиг, алдагдал нь 107.7 сая төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 95.3 хувиар буюу 52.5 сая төгрөгөөр өссөн байна.

Тайлант улиралд 169 ХЗХ-д 865.1 сая төгрөгийн ашигтай, 19 ХЗХ ашиг, алдагдалгүй тус тус ажиллаж салбарын хэмжээнд нийт 484,070.4 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна. Салбарын ашгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 138.3 сая төгрөгөөр буюу 22.2 хувиар буурсан үзүүлэлттэй байна

Хүснэгт 11: ХЗХ-дын ашгийн хэмжээ /бүлгээр/

| Ашгийн хэмжээ /интервалаар/ | ХЗХ-дын тоо | Ашгийн хэмжээ /сая төгрөг/ | Нийт ашигт эзлэх хувь | Активын хэмжээ /тэрбум төгрөг/ | Нийт хөрөнгийн өгөөж |
|---|---|---|---|---|---|
| 100 саяас дээш | 2 | 294.5 | 34.0% | 19.4 | 1.52% |
| 50 саяас 100 сая | - | - | - | - | - |
| 10 саяас 50 сая | 13 | 310.3 | 35.9% | 14.8 | 2.1% |
| 5 саяас 1 0 сая | 13 | 94.9 | 11.0% | 5.6 | 1.7% |
| 1 саяас 5 сая | 58 | 138.4 | 16.0% | 12.6 | 1.1% |
| 1 сая хүртэл | 83 | 27.1 | 3.1% | 10.9 | 0.2% |
| Ашиг, алдагдалгүй | 19 | - | - | 0.5 | - |
| **Нийт дүн** | **188** | **865.1** | **100%** | **63.8** | **1.4%** |

*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

# VI. ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

## 6.1 БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

2017 оны 1 дүгээр улиралд чанаргүй зээл 13.4 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 2.0 нэгжээр, өмнөх улирлаас 1.0 нэгжээр тус тус өсөөд байна. Хугацаа хэтэрсэн зээл 6.0 хувь болж өмнөх оны мөн үеэс 1.3 нэгжээр бууран, өмнөх улирлаас 0.4 нэгжээр өсжээ.

Зураг 46: Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн хувь




*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

Зээлийн эрсдэлийн түвшинг ББСБ бүрээр тооцоход нийт 34 ББСБ 50-аас дээш хувийн эрсдэл хүлээхээр байгаа бөгөөд эдгээр нь 6 хувийг эзэлж байна.

Зураг 47: ББСБ бүрийн хугацаа хэтэрсэн ба чанаргүй зээлийн хувь




*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

ББСБ –уудын хувь нийлүүлсэн хөрөнгө арилжааны банкуудын хувь нийлүүлсэн хөрөнгийн 90-ээд хувьтай тэнцдэг тул бичил санхүүгийн салбарыг хөгжүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулах юм. Гэвч ББСБ-уудын чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээ нэмэгдэж байгаа нь тэдгээрийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх учир “Алтманы индекс”-ийг ашиглан дампуурах магадлалыг тооцлоо.

Тэгшитгэл 1. Алтманы индекс

$$\textbf{Алтманы индекс} = 1.2X_1 + 1.4X_2 + 2.3X_3 + 0.6X_4 + 0.999X_5$$

*Эх сурвалж: Managing credit risk*

Хүснэгт 12: Алтманы индекс

| | Алтманы индекс | | | | | Алтманы индекс |
|---|---|---|---|---|---|---|
| | 1.2X | 1.4X | 2.3X | 0.6X | 0.999X | |
| | Ажлын капитал/нийт хөрөнгө | Хуримтлагдсан ашиг/нийт хөрөнгө | Хүү, татварын өмнөх ашиг/нийт хөрөнгө | Эзэмшигчдийн өмчийн бодит үнэ цэнэ/өр төлбөрийн дансны үнэ | Нийт орлого/нийт хөрөнгө | |
| ББСБ-ын салбар | 1.03 | 0.21 | 0.04 | 0.6 | 0.05 | 1.98 |

*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

Алтманы индексээр тооцсоны дагуу 5 ББСБ 2.99-өөс дээш, 387 ББСБ 1.81-2.99 индексийн хооронд гарч дампуурах магадлал ажиглагдаагүй бол 137 ББСБ 1.81-ээс доош индекстэй гарч дампуурах магадлалтай бүсэд орсон байна.

Уг 137 ББСБ-ын нийт хөрөнгө 273.9 тэрбум төгрөг буюу салбарын нийт хөрөнгийн 34.3 хувь, нийт зээлийн үлдэгдэл 158.8 тэрбум төгрөг буюу 31.6 хувийг бүрдүүлж байна.

## 6.2 ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО

Тайлант улиралд өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт зээл 20 хувиар өсөж 96.7 тэрбум төгрөгт хүрсэн байна. Харин чанаргүй зээлийн хувьд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 30 хувиар буюу 1 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Зураг 48: Нийт зээл болон чанаргүй зээл /тэрбум төгрөгөөр/




*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

Тайлант хугацаанд өмнөх оны мөн улиралтай харьцуулахад хугацаа хэтэрсэн зээл болон чанаргүй зээлийн хэмжээ, нийт зээлд эзлэх хувь өссөн бол хэвийн зээлийн нийт зээлд эзлэх хувь 0.9 хувиар буурсан байна.

Зураг 49: ХЗХ-дын зээлийн чанар /тэрбум төгрөгөөр/

*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

Татан төвлөрүүлсэн хадгаламжийн хэмжээ 74.7 тэрбум төгрөг буюу нийт өр төлбөрийн 76.1 хувийг эзэлж байна. Татан төвлөрүүлсэн хадгаламжийн үлдэгдлийг ангилахад 1 тэрбум төгрөгөөс дээш хадгаламжийн үлдэгдэлтэй 11 ХЗХ-ны хадгаламжийн үлдэгдэл 61.2 тэрбум төгрөг байгаа нь нийт ХЗХ-дын хадгаламжийн үлдэгдлийн 81.9 хувийг эзэлж байгаа бол хадгаламж татан төвлөрүүлээгүй 23 ХЗХ байгаа нь нийт ХЗХ-дын 8.1 хувийг эзэлж байна.

Хүснэгт 13: ХЗХ-дын хадгаламжийн үйл ажиллагаа /тэрбум төгрөгөөр/

| № | Хадгаламжийн хэмжээ /интервалаар/ | ХЗХ-дын тоо | Хадгаламжийн дүн /тэрбум төгрөг/ | Нийт хадгаламжид эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| 1 | 10 тэрбумаас дээш | 1 | 29.6 | 39.6 % |
| 2 | 1 тэрбумаас 10 тэрбум | 10 | 31.6 | 42.3 % |
| 3 | 500 саяас 1 тэрбум | 5 | 3.3 | 4.4 % |
| 4 | 100 саяас 500 сая | 30 | 6:7 | 8.9 % |
| 5 | 50 саяас 100 сая | 16 | 1.2 | 1.6 % |
| 6 | 10 саяас 50 сая | 93 | 1.9 | 2.6 % |
| 7 | 5 саяас 10 сая | 50 | 0.4 | 0.48 % |
| 8 | 5 сая хүртэл | 54 | 0.1 | 0.16 % |
| 9 | Хадгаламжгүй | 23 | - | - |
| **Нийт хадгаламжийн дүн** | | **282** | **74.7** | **100.0%** |

*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

# ХАВСРАЛТ

Хавсралт 1: Хөрөнгийн зах зээлийн статистик үзүүлэлт /тэрбум төгрөгөөр/

| Огноо | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017Q1 |
|---|---|---|---|---|---|---|
| Зах зээлийн үнэлгээ | 1,799.90 | 1,670.50 | 1,442.60 | 1,262.50 | 1,474.20 | 1,429.2 |
| ЗЗҮ-ний ДНБ-д харьцуулсан хувь | 10.70% | 8.70% | 7.00% | 5.40% | 6.20% | - |
| Нийт арилжаа(тэрбум төгрөгөөр): Үүнээс | | | | | | |
| Хувьцааны арилжааны хэмжээ | 144.7 | 97.5 | 24.2 | 30.4 | 49 | 5.0 |
| ЗГҮЦ-ны арилжаа | 0.001 | 1.01 | 36.11 | 515.46 | 299.63 | 133.2 |
| Компанийн бондын арилжаа | 0.31 | - | - | 0.502 | - | - |
| Анхдагч зах зээлийн арилжаа: Үүнээс | | | | | | |
| Хувьцаа | 0.924 | - | 2.0 | 20.1 | 6.2 | - |
| ЗГҮЦ | - | - | 36.1 | 510.3 | 280.45 | 119.5 |
| Компанийн бонд | - | - | - | 0.5 | - | - |
| Хоёрдогч зах зээлийн арилжаа :Үүнээс | | | | | | |
| Хувьцаа | 143.82 | 97.59 | 22.18 | 10.36 | 42.85 | 5.0 |
| ЗГҮЦ | 0.001 | 1.01 | - | 5.12 | 19.1 | 13.7 |
| Компанийн бонд | 0.31 | - | - | 0.002 | - | - |
| Арилжааны хэмжээ /хөрөнгө оруулагчаар/ | | | | | | |
| Дотоодын иргэн | 8.15 | 5.99 | 19.66 | 27.14 | 28.22 | 50.1 |
| Дотоодын ААН | 2.52 | 79.55 | 33.75 | 510.03 | 287.65 | 80.2 |
| Гадаадын иргэн | 2.74 | 2.1 | 3.14 | 5.91 | 6.04 | 0.697 |
| Гадаадын ААН | 131.65 | 10.97 | 3.82 | 3.33 | 1.82 | 6.5 |
| Хөрвөх чадвар | 8.04% | 5.84% | 1.68% | 2.41% | 3.33% | - |
| Топ-20 индекс | 16,839.1 | 15,874.0 | 14,833.0 | 12,279.0 | 11,605.7 | 12,679.1 |
| Бүртгэлтэй компанийн тоо | 328 | 323 | 304 | 299 | 302 | 302 |
| Брокер, дилерийн компанийн тоо | 95 | 87 | 66 | 62 | 62 | 62 |
| Үнэт цаасны данс эзэмшигчдийн тоо | 766,184 | 775,323 | 785,863 | 804,964 | 886,590 | 890,780 |
| Хөдөө аж ахуйн биржийн арилжаа | - | 404.13 | 554.09 | 422.37 | 454.91 | 30.8 |

*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

Хавсралт 2: Даатгалын зах зээлийн статистик үзүүлэлт /тэрбум төгрөгөөр/

| Үзүүлэлт | 2012.I | 2013.I | 2014.I | 2015.I | 2016.I | 2017.I |
|---|---|---|---|---|---|---|
| Хөрөнгө (тэрбум төгрөг) | | | | | | |
| Нийт хөрөнгө | 84.41 | 104.84 | 124.97 | 170.20 | 188.88 | 224.76 |
| Ердийн даатгалын компаниудын нийт хөрөнгө | 80.85 | 100.05 | 119.12 | 140.23 | 151.93 | 180.83 |
| Урт хугацааны даатгалын компанийн нийт хөрөнгө | 3.56 | 4.78 | 5.85 | 6.71 | 7.67 | 7.70 |
| Давхар даатгалын компанийн нийт хөрөнгө | 0.00 | 0.00 | 0.00 | 23.26 | 29.29 | 36.24 |
| Нийт хөрөнгийн өсөлт | 44.5% | 24.2% | 19.2% | 36.2% | 11.0% | 19.0% |
| Хураамжийн орлого (тэрбум төгрөг) | | | | | | |
| Хураамжийн нийт орлого | 17.77 | 15.86 | 23.90 | 35.54 | 27.21 | 37.51 |
| Ердийн даатгалын компаниудын хураамжийн нийт орлого | 17.67 | 15.63 | 23.47 | 35.03 | 26.91 | 36.61 |
| Урт хугацааны даатгалын компанийн хураамжийн нийт орлого | 0.10 | 0.23 | 0.43 | 0.51 | 0.30 | 0.40 |
| Давхар даатгалын компанийн хураамжийн нийт орлого | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.50 |
| Нөхөн төлбөр (тэрбум төгрөг) | | | | | | |
| Нийт нөхөн төлбөр | 2.95 | 6.46 | 8.35 | 9.37 | 8.93 | 8.81 |
| Ердийн даатгалын компаниудын нийт нөхөн төлбөр | 2.91 | 6.41 | 8.24 | 9.15 | 8.72 | 8.64 |
| Урт хугацааны даатгалын компанийн нийт нөхөн төлбөр | 0.04 | 0.04 | 0.11 | 0.22 | 0.21 | 0.18 |
| Давхар даатгалын компанийн нийт нөхөн төлбөр | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| Нөөц сан (тэрбум төгрөг) | | | | | | |
| Нөөц сан | 36.36 | 45.62 | 58.53 | 69.81 | 84.94 | 105.39 |
| Ердийн даатгалын компаниудын нийт нөөц сан | 36.04 | 44.92 | 57.41 | 61.39 | 1.48 | 90.32 |
| Урт хугацааны даатгалын компанийн нийт нөөц сан | 0.31 | 0.70 | 1.12 | 1.43 | 10.63 | 1.65 |
| Давхар даатгалын компанийн нийт нөөц сан | 0.00 | 0.00 | 0.00 | 7.00 | 72.84 | 13.41 |
| Давхар даатгалын хураамж (тэрбум төгрөг) | | | | | | |
| Давхар даатгалын хураамж | 8.06 | 5.92 | 9.85 | 20.82 | 13.12 | 20.02 |
| Ердийн даатгалын компаниудын давхар даатгалын хураамж | 8.05 | 5.92 | 9.85 | 20.82 | 13.11 | 19.80 |
| Урт хугацааны даатгалын компанийн давхар даатгалын хураамж | 0.002 | 0.002 | 0.002 | 0.002 | 0.009 | 0.005 |
| Давхар даатгалын компанийн давхар даатгалын хураамж | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.21 |
| Цэвэр ашиг (тэрбум төгрөг) | | | | | | |
| Цэвэр ашиг | 2.24 | 1.09 | -0.54 | 0.97 | 3.49 | 0.88 |
| Ердийн даатгалын компаниудын цэвэр ашиг | 2.26 | 1.13 | -0.58 | 0.16 | 3.47 | -0.19 |
| Урт хугацааны даатгалын компанийн цэвэр ашиг | -0.02 | -0.04 | 0.03 | 0.11 | 0.02 | 0.04 |
| Давхар даатгалын компанийн цэвэр ашиг | 0.00 | 0.00 | 0.00 | 0.71 | 0.00 | 1.02 |
| Цэвэр ашгийн өсөлт | 12.9% | -51.1% | -149.69% | -279.23% | 258.53% | -74.87% |

| Мэргэжлийн оролцогчид (тоо, ширхэг) | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Ердийн даатгал | 17 | 16 | 16 | 15 | 15 | 15 |
| Урт хугацааны даатгал | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 |
| Давхар даатгал | * | * | * | 1 | 1 | 1 |
| Даатгалын төлөөлөгч | 2357 | 3187 | 3260 | 3340 | 3091 | 3074 |
| Даатгалын зуучлагч | 17 | 20 | 30 | 37 | 40 | 41 |
| Хохирол үнэлэгч | 9 | 14 | 20 | 27 | 31 | 30 |
| Актуарч | 18 | 15 | 15 | 15 | 15 | 15 |
| Аудитор | 43 | 69 | 84 | 124 | 126 | 126 |
| Аудитын компани | 16 | 22 | 30 | 40 | 42 | 42 |

*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

Хавсралт 3: ББСБ-уудын статистик үзүүлэлт (тэрбум төгрөгөөр)

| Огноо | 2012.I | 2013.I | 2014.I | 2015.I | 2016.I | 2017.I |
|---|---|---|---|---|---|---|
| **Нийт хөрөнгө** | 213.2 | 282.5 | 404.8 | 515.9 | 634.1 | 798.3 |
| **Эргэлтийн хөрөнгө** | 206.1 | 271.8 | 391.6 | 499.2 | 609.1 | 762.6 |
| Мөнгөн хөрөнгө | 61.8 | 70.3 | 114.0 | 139.1 | 178.7 | 227.0 |
| Богино хугацаат хөрөнгө оруулалт | 3.3 | 9.3 | 10.6 | 11.5 | 1.6 | 2.9 |
| Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө (цэврээр) | 0.9 | 0.9 | 1.2 | 2.0 | 2.1 | 5.4 |
| Эргэлтийн бус хөрөнгө | 7.2 | 10.7 | 13.3 | 16.7 | 25.1 | 35.7 |
| Нийт өр төлбөр | 70.5 | 101.3 | 154.8 | 178.5 | 178.5 | 162.8 |
| Итгэлцлийн үйлчилгээний өглөг | 13.2 | 17.7 | 22.2 | 28.5 | 29.4 | 32.3 |
| Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг | 42.0 | 61.6 | 96.0 | 120.8 | 110.8 | 62.7 |
| Төслийн зээлийн санхүүжилт | 4.0 | 7.7 | 10.4 | 13.4 | 15.0 | 36.0 |
| Эзэмшигчдийн өмч | 142.7 | 181.2 | 249.9 | 337.4 | 455.6 | 635.5 |
| Хоёрдогч өглөг | 2.7 | 1.6 | 1.7 | 1.8 | 0.8 | 0.9 |
| Хувьцаат капитал | 121.1 | 148.4 | 198.8 | 262.0 | 341.3 | 509.8 |
| Хуримтлагдсан ашиг | 14.5 | 23.6 | 41.9 | 65.7 | 101.8 | 117.8 |
| ББСБ-ын тоо | 194 | 229 | 289 | 395 | 463 | 529 |
| Үүнээс: УБ хот | 194.0 | 204 | 254 | 354 | 411 | 466 |
| Хөдөө, орон нутаг | | 25 | 35 | 41 | 52 | 63 |
| Харилцагчдын тоо | 94,256 | 278,686 | 288,017 | 405,558 | 445,918 | 1,311,886 |
| Зээлийн хүүгийн орлого | 9.1 | 13.83 | 19.4 | 26.1 | 32.8 | 36.9 |
| Үнэт цаасны арилжааны орлого | 0.2 | 0.004 | 0.00001 | 0.001 | 0.002 | 0.005 |
| Валютын арилжааны орлого | 0.99 | 0.6 | 1.1 | 0.8 | 0.7 | 0.9 |
| Санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл | 0.02 | 0.03 | 0.2 | 0.2 | 0.05 | 0.03 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Нийт орлого | 15.0 | 17.9 | 33.7 | 37.0 | 41.0 | 45.2 |
| Хүүгийн орлого | 9.5 | 14.3 | 19.6 | 26.6 | 33.5 | 37.1 |
| Хүүгийн бус орлого | 4.95 | 3.3 | 13.6 | 9.9 | 6.8 | 6.4 |
| Үндсэн бус үйл ажиллагааны орлого | 0.5 | 0.3 | 0.4 | 0.4 | 0.7 | 1.7 |
| Нийт зардал | 10.9 | 12.2 | 26.1 | 28.1 | 33.9 | 32.3 |
| Хүүгийн зардал | 1.4 | 1.8 | 3.1 | 4.1 | 4.3 | 4.0 |
| Хүүгийн бус зардал | 8.0 | 8.2 | 19.6 | 18.2 | 16.6 | 19.9 |
| Болзошгүй эрсдэлийн зардал | 0.6 | 1.2 | 2.0 | 4.3 | 5.6 | 5.9 |
| Үндсэн бус үйл ажиллагааны зардал | 0.4 | 0.2 | 0.4 | 0.2 | 0.2 | 0.7 |
| Цэвэр ашиг | 4.1 | 5.7 | 7.6 | 8.9 | 12.7 | 12.9 |
| Нийт зээл | 129.3 | 175.3 | 245.4 | 332.2 | 400.5 | 502.4 |
| Хэвийн зээл | 121.5 | 164.0 | 221.8 | 284.3 | 325.6 | 404.8 |
| Хугацаа хэтэрсэн зээл | 2.7 | 4.4 | 11.4 | 23.6 | 29.2 | 30.1 |
| Чанаргүй зээл | 5.1 | 6.9 | 12.2 | 24.3 | 45.7 | 67.5 |
| Зээлийн эрсдэлийн сан | 3.8 | 4.8 | 8.1 | 18.9 | 30.4 | 45.8 |

*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

Хавсралт 4: ХЗХ-дын статистик үзүүлэлт (тэрбум төгрөгөөр)

| | 2012.I | 2013.I | 2014.I | 2015.I | 2016.I | 2017.I |
|---|---|---|---|---|---|---|
| ХЗХ-дын тоо | 158 | 144 | 140 | 207 | 271 | 282 |
| УБ | 69 | 61 | 57 | 124 | 175 | 185 |
| Орон нутаг | 89 | 83 | 83 | 83 | 96 | 97 |
| ХЗХ-дын тооны өсөлт | -11.2% | -8.9% | -2.8% | 47.9% | 30.9% | 4.1% |
| Гишүүдийн тоо /мянга/ | 26.2 | 26.0 | 27.0 | 32.8 | 41.8 | 47.9 |
| Нийт хөрөнгийн дүн /тэрбум төгрөг/ | 67.1 | 71.4 | 76.0 | 85.8 | 101.5 | 121.7 |
| Нийт хөрөнгө/ДНБ | 2.1% | 2.0% | 1.8% | 1.9% | 2.1% | 2.1% |
| Мөнгөн хөрөнгө | 10.9 | 11.7 | 10.2 | 10.2 | 16.6 | 20.0 |
| Нийт зээл | 53.5 | 56.1 | 61.7 | 71.6 | 80.3 | 96.7 |
| Хэвийн зээл | 50.1 | 53.4 | 58.3 | 67.4 | 73.2 | 87.2 |
| Хугацаа хэтэрсэн зээл | 1.1 | 1.3 | 1.8 | 2.2 | 3.7 | 5.0 |
| Чанаргүй зээл | 2.4 | 1.3 | 1.6 | 2.0 | 3.5 | 4.5 |
| Өр төлбөр | 53.7 | 55.6 | 59.4 | 67.2 | 81.0 | 98.1 |
| Хадгаламж | 48.4 | 49.7 | 52.2 | 56.7 | 62.8 | 74.7 |
| Богино хугацаат зээл | 1.5 | 1.6 | 1.4 | 3.8 | 1.4 | 3.3 |
| Урт хугацаат өр төлбөр | 0.3 | 0.5 | 0.5 | 2.3 | 12.0 | 13.6 |
| Бусад богино хугацаат өр төлбөр | 3.5 | 3.7 | 5.3 | 4.5 | 4.8 | 6.6 |
| Нийт орлого | 4.0 | 4.1 | 4.5 | 5.0 | 6.1 | 6.9 |
| Хүүгийн орлого | 3.7 | 3.9 | 4.4 | 4.9 | 5.9 | 6.5 |
| Нийт зарлага | 3.5 | 3.2 | 3.7 | 4.6 | 5.5 | 6.5 |
| Хүүгийн зарлага | 2.1 | 2.1 | 2.3 | 2.7 | 3.1 | 3.5 |

*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*